

# ХҮРТЭЭМЖТЭЙ САНХҮҮ

Санхүүгийн зохицуулах хорооны товхимол

2020 · 11 сар | Дугаар 24

## ГАРЧИГ

- 2–3 Бодлогын нийтлэл  
3–4 Зохицуулалтын мэдээ  
5–6 Манай улсын даатгалын зах зээлд өргөжих боломж бий  
7 Даатгалын зах зээлийн ёс зүйн журам  
8–10 8–10 Даатгалын салбарын технологид суурилсан санхүүгийн үйлчилгээ  
11–15 Зээлдэгч өөрийн санхүүгийн хэрэгцээ, чадамжид нийцсэн зээлээр санхүүжиж байгаа эсэх  
15–16 Хүртээмжтэй даатгалын асуудлаарх азийн орнуудын мэдлэг, туршлага солилцох сүлжээ  
17–18 Өргөн дуран  
19–20 Даатгалын ач холбогдол  
21 Хөрөнгө, оруулагч үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах  
22 Компанийн засаглал  
23–24 ОУ-ын хөрөнгийн зах зээлийн мэдээ  
25–27 Санхүүгийн зах зээлийн сарын мэдээ  
28 Олон улсын хөрөнгийн зах зээлийн индекс

## Хүртээмжтэй санхүү

Санхүүгийн зохицуулах хорооны товхимол

8 Засгийн газрын IV байр, Бага тойруу-3 Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, Монгол Улс 15160

9 +976-51-264444

10 press@frc.mn

11 www.frc.mn

12 Санхүүгийн зохицуулах хороо


13 @FRC\_of\_Mongolia

Зах зээлийн судалгаа, хөгжлийн газар

## МАНАЙ УЛСЫН ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛД ӨРГӨЖИХ БОЛОМЖ БИЙ

Санхүүгийн зохицуулах хорооны Даатгалын газрын дарга

**З.Батболдтой** ярилцлаа.



**Сайн байна уу? Та даатгалын салбарын өнөөгийн байдал, цаашдын хөгжлийг хэрхэн үнэлж байна вэ?**

Монгол Улсад даатгалын салбар үүсэж хөгжөөд 86 жил болсон байна. 1934 онд Улсын аюулаас хамгаалах газар нэртэй анхны даатгалын байгууллага бий болж, улмаар Монгол Улс зах зээлийн харилцаанд шилжин орсноор 1990 онд Засгийн газрын шийдвэрээр Улсын даатгалын ерөнхий газрыг өөрчлөн зохион байгуулсан. Ийнхүү “Монгол даатгал” төрийн өмчит үйлдвэрийн газар байгуулагдсанаар арилжааны даатгалын компаниуд бий болох суурь тавигдсан юм. Өдгөө Санхүүгийн зохицуулах хорооноос олгосон тусгай зөвшөөрөлтэйгөөр 14 ердийн даатгалын, 1 урт хугацааны, 1 давхар даатгалын компани, 54 даатгалын зуучлагч, 26 даатгалын хохирол үнэлэгч, 2,448 даатгалын төлөөлөгч энэ зах зээлд үйл ажиллагаагаа явуулж байгаа бөгөөд тэдгээр нь 700 орчим даатгалын бүтээгдэхүүн үйлчилгээг 1 сая гаруй даатгуулагчдад хүргэн ажиллаж, жилд 90 гаруй их наяд төгрөгийн үнэлгээ бүхий эрсдэлийг хүлээн авч, даатгуулагчдад учирсан 60 гаруй тэрбум төгрөгийн хохирлыг барагдуулж ажилладаг болжээ.

Манай улсын даатгалын салбарын өнөөгийн байдлыг бүтэц, төвлөрлийн хувьд дүгнэн харвал ердийн даатгал давамгайлсан буюу нийт хураамжийн орлогын 99.4 хувийг ердийн даатгалын хураамж эзэлдэг ба үүний 82 хувийг бүрдүүлж буй 7 ердийн даатгалын

компанийн 4 нь нээлттэй хувьцаат компани болсон байна. Мөн даатгалын хэлбэрийн хувьд хөрөнгийн даатгал нь нийт хураамжийн бараг 4-ний нэгийг, түүнд хамрагдсан даатгуулагчид нь нийт даатгуулагчдын 8-ны нэгийг бүрдүүлдэг бол жижиглэнгийн / retail consumer/ буюу иргэд, байгууллагын ажилтан, албан хаагчдад чиглэсэн сайн дурын даатгал болох гэнэтийн осол, эмчилгээний даатгал, тээврийн хэрэгслийн даатгал нийт даатгуулагчдын 21.5, нийт хураамжийн 34 хувийг бүрдүүлдэг. Харин албан журмын арилжааны даатгалын цорын ганц хэлбэр болох Жолоочийн даатгал нь хураамжийн орлогын 20 орчим хувийг, даатгуулагчдын 60 хувийг дангаараа бүрдүүлж байна.

Иргэд, олон нийтийг урт хугацаанд учирч болох эрсдэлүүдээс хамгаалж, хуримтлал, хөрөнгө оруулалтыг бий болгох боломжтой урт хугацааны даатгал болон улс орны эрсдэлийн менежментийн томоохон тоглогч болох давхар даатгалын зах зээлийн хөгжил манай улсад сул байгаа бөгөөд нийт даатгалын хураамжийн 30–40 гаруй хувийг гадны давхар даатгалд шилжүүлж байна.

Сүүлийн 5 жилийн байдлаар салбарын хөрөнгийн хэмжээ жилд дунджаар 19.4 хувиар, даатгалын хураамжийн хэмжээ 13.1 хувиар өсөж, даатгалын зах зээл эрчимтэй хөгжин, малчин айл өрхийг ядуурлаас хамгаалах хүрээнд малыг ган зудын аюулаас даатгах, зам тээврийн ослын хохирлыг бууруулах, ипотекийн зээлдэгчдийг эрсдэлээс хамгаалах зэргээр тус салбарын нийт эдийн засагт эзлэх хувь хэмжээ, гүйцэтгэх үүрэг, ач холбогдол жилээс жилд өсөн нэмэгдэх хандлагатай байна. Гэсэн хэдий ч манай улсын даатгалын нэвтрэлтийн түвшин буюу даатгалын хураамжийн орлогын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь 0.56, даатгалын нягтрал буюу нэг хүн амд ногдох даатгалын хураамжийн орлогын дүн ойролцоогоор 21.50 ам.доллантай /60,708 төг/ тэнцүү байна. Энэ нь хөгжиж буй улс орнуудын дунджаас тус тус 6 болон 8 дахин бага үзүүлэлт боловч энэ хэмжээгээр манай улсын даатгалын зах зээл өргөжих боломжтой гэж үзэж байгаа.

Ургэлжлэл 5-р нүүрт >>

## Санхүүгийн зохицуулах хорооны

### АЛСЫН ХАРАА

Чөлөөт, шударга өрсөлдөөнт, хэрэглэгчдийн эрх хамгаалагдсан, хүртээмжтэй, олон тулгуурт тогтвортой санхүүгийн зах зээлийг цогцлоож эдийн засгийн өсөлт, хөгжлийг тэтгэнэ.

### ЭРХЭМ ЗОРИЛГО

Санхүүгийн зохистой бодлого, үр ашигтай хяналт шалгалт, оновчтой зохицуулалтыг хэрэгжүүлж олон тулгуурт, хэрэглэгчдийн эрхийг хамгаалсан, итгэлийг нэмэгдүүлсэн тогтвортой санхүүгийн зах зээлийг хөгжүүлнэ.

### ҮНЭТ ЗҮЙЛС

**Цогц мөн чанар:** Хүнлэг, үнэнч, шударга, итгэлтэй, өндөр ёс суртахуунтай байх нь;

**Хариуцлагатай байх:** Ажил үүргээ гүнээ ухамсарлаж, чин эрмэлзэлтэй, ажлын цагаа ажилдаа бүрэн зориулдаг, хичээнгүй нямбай, түргэн шуурхай, хувийн зохион байгуулалт сайн байх нь;

**Мэргэжлийн байх:** Өндөр мэдлэг, үр чадвар эзэмшсэн, өрсөлдөх чадвартай, ёс зүйтэй, зөв шийдэл гаргах чадвартай байх нь;

**Бие даасан байх:** Хувийн ашиг сонирхлоос ангид, хөндлөнгийн нөлөөгүй, хуулийн хүрээнд үйл ажиллагаа явуулах нь;

**Манлайлал, санаачлагатай байх:** Шинийг эрэлхийлэгч, сайжруулан хөгжүүлэгч, манлайлагч, бүтээлч тэмүүлэлтэй байх нь;

**Багаар ажиллах:** Нэг зорилгын төлөө мэдлэг мэдээллээ хуваалцах, хамт олноо сонсох, итгэл хүндэтгэлтэй хандах, дэмжин туслах, жигд оролцоотойгоор үр өгөөжтэй хамтран ажиллах чадвартай байх нь

**Бидний үнэт зүйлс юм.**



## БОДЛОГЫН НИЙТЛЭЛ

### ДААТГАГЧ БОЛОН ДААТГАЛЫН МЭРГЭЖЛИЙН ОРОЛЦОГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТАВИГДАХ ШААРДЛАГА



Санхүүгийн зохицуулах хороо нь Даатгалын тухай, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн дагуу даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох, тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг биелүүлж байгаа эсэхэд болон үйл ажиллагаанд хяналт тавих, Даатгалын багц дүрмийг батлах, хэрэгжүүлэх, хэрэгжилтэд нь хяналт тавих, даатгалын дотоод, гадаад зах зээлийг судлах, даатгалын талаарх албан ёсны мэдээлэл гаргах, даатгагч, даатгалын мэргэжлийн оролцогчийн нэгдсэн бүртгэл хөтлөх зэрэг бүрэн эрхийг хэрэгжүүлж ажилладаг.

Даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагааг зохицуулах дүрэм, журам, заавар, нөхцөл шаардлагыг багтаасан “Даатгалын багц дүрэм”-ийг Захиргааны ерөнхий хуульд нийцүүлэн шинэчлэн боловсруулж, Хорооны 2019 оны 02 дугаар тогтоолоор баталсан.

Манай улсын даатгалын салбарын бүтээгдэхүүн, үйлчилгээ, түүний чанар хүртээмж жилээс жилд сайжирч байгаа хэдий ч иргэд, аж ахуйн нэгжийн даатгалд хамрагдалтын түвшин олон улстай харьцуулахад, мөн даатгалын хураамжийн орлого бусад санхүүгийн салбарын орлогын Монгол Улсын ДНБ-д эзэлж буй хэмжээтэй харьцуулахад тус тус харьцангуй доогуур түвшинд байна. Иймд иргэдийн даатгалын талаарх ойлголт хандлага, даатгалд итгэх

итгэлийг нэмэгдүүлэх замаар даатгалын хамрагдалтыг өсгөхийн тулд даатгалын үйл ажиллагааг зохистой явуулах, даатгалын компанид зохистой засаглалын зарчим, эрсдэлийн удирдлагын тогтолцоог бүрдүүлэх, мэдээллийн ил тод байдлыг дээшлүүлэх, даатгуулагч, үйлчлүүлэгчийн эрх ашгийг хамгаалахтай холбоотой нөхцөл шаардлагуудыг сайжруулах шаардлага үүсээд байна.

Хороо нь Улсын Их Хурал болон Засгийн газраас баталсан бодлого, стратегийн баримт бичгүүдэд тусгагдсан арга хэмжээ, Олон улсын даатгалын хянан шалгагчдын холбооноос боловсруулсан Даатгалын тулгуур зарчим (ICP), зөвлөмжид тулгуурлан гадаад улс орнуудын зохицуулалтын орчин, сайн туршлага, салбарын үйл ажиллагаанд тулгамдаж буй асуудлуудыг судалж, даатгалын салбарт зарчимд суурилсан тогтолцоог бий болгох зорилготойгоор “Даатгалын багц дүрэм”-ийн нэгдүгээр хавсралт “Даатгалын, даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг авах хүсэлт гаргахад бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт болон даатгагч, даатгалын мэргэжлийн оролцогчид тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлт”-ийг “Даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогчид тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлт” гэж шинэчлэн, арван наймдугаар хавсралтаар “Тусгай зөвшөөрөл авах хүсэлт гаргахад бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт” гэж батлахаар эрх зүйн актуудын төслийг боловсруулсан.

Дээрх эрх зүйн актуудын төсөлд орсон өөрчлөлт, шинэчлэгдсэн зохицуулалтуудаас дурдвал:

- Тусгай зөвшөөрөл хүссэн иргэд, хуулийн этгээд болон тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд илүү ойлгомжтой, хэрэглэхэд хялбар дөхөм болгох, бүртгэл, зөвшөөрлийн үйл ажиллагааг олон улсын стандарт, цаг үеийн чиг хандлагад нийцүүлэн боловсронгуй болгож цахимжуулахтай холбогдох

- зохицуулалтыг тусгасан;
- Санхүүгийн салбарын өрсөлдөөн болон хүртээмжийг дэмжих, бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлэх зорилгоор даатгалын бүтээгдэхүүнийг зохицуулагч байгууллагаас зөвшөөрөл авсны үндсэн дээр зах зээлд борлуулдаг зохицуулалтыг (prior approval) өөрчилж зарчимд суурилсан (principle based) зохицуулалтыг бий болгосон;
- Санхүүгийн шинэ технологид суурилсан бүтээгдэхүүн, үйлчилгээг дэмжих, зохицуулалтын орчинг сайжруулах зорилгын хүрээнд даатгагч, даатгалын зуучлагч нь цахимаар болон аливаа дэвшилтэт технологи ашиглан даатгалын гэрээг байгуулахад тавигдах шаардлага болон даатгагчийн ТУЗ-өөс баталж, хэрэгжүүлэх технологид суурилсан шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ, бизнес загварыг хөгжүүлэх бодлого, журамтай байх шаардлагыг тусгасан;
- Азийн хөгжлийн банкны “ТА-9808 МОН:Санхүүгийн хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах хуулийн зохицуулалтыг

- хөгжүүлэх” төслийн хүрээнд Олон улсын зөвлөхийн боловсруулсан “Даатгагч, даатгалын мэргэжлийн оролцогчийн бизнесийн үйл ажиллагааг зохистой явуулах журам”-ын төслийг судалж, даатгуулагчийн эрх ашгийг хамгаалах зохицуулалтыг сайжруулах зорилгоор даатгагч, даатгалын мэргэжлийн оролцогч нь даатгалын гэрээг байгуулахаас өмнөх болон гэрээ байгуулагдсаны дараах шаардагдах мэдээллүүдийг үйлчлүүлэгчид өгөх, авахтай холбогдох шаардлагыг тусгасан;
- Компанийн засаглалын сайн тогтолцоог бүрдүүлэх зорилгоор Даатгагчийн үйл ажиллагаанд ТУЗ-ийн гүйцэтгэх үүргийг тодорхой болгож, эрсдэлийн удирдлагын хараат бус тогтолцоог бүрдүүлэх, сайжруулах хүрээнд эрсдэлийн удирдлагын нэгж, үйлчлүүлэгчийн өргөдөл, гомдлыг барагдуулдаг, эрх ашгийг хамгаалдаг нэгжтэй байх, тус нэгжүүд нь өөр хоорондоо хараат бус хяналт тавих зохицуулалтыг тусгасан;
- Даатгалын зах зээлийн мэдээллийн ил тод байдлыг хангах зорилгоор даатгагч,

даатгалын мэргэжлийн оролцогч өөрийн үйл ажиллагаатай холбогдох мэдээллийг цахим хуудсанд байршуулж, олон нийтэд мэдээлэх зохицуулалтыг сайжруулсан;

- Даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагааг илүү мэргэжлийн түвшинд явуулах, даатгалын байгууллагад ажиллаж буй боловсон хүчнийг мэргэшүүлэх бодлоготой байх, холбогдох байгууллагаас зохион байгуулдаг мэргэжлийн сургалтад тогтмол хамруулах шаардлагыг шинэчлэсэн;
- Даатгалын үйл ажиллагаатай холбогдох бүртгэл хөтлөх, мэдээллийн сан үүсгэх шаардлагыг тусгасан.

Энэхүү өөрчлөлтүүд нь хариуцлагатай даатгагч, даатгалын мэргэжлийн оролцогч, мэргэшсэн боловсон хүчинтэй, технологид суурилсан бүтээгдэхүүн, үйлчилгээтэй, ёс зүйтэй даатгалын салбар бүрэлдэх хөшүүргийг бий болгож, даатгалын зах зээл өргөжих боломжийг бүрдүүлэх юм.

## ЗОХИЦУУЛАЛТЫН МЭДЭЭ

### ҮНДЭСНИЙ ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭГ ХЭЛЭЛЦҮҮЛЛЭЭ

Монгол Улс мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх үндэсний эрсдэлийн үнэлгээг 2016 онд анх хэрэгжүүлсэн. Энэ үнэлгээг шинэчлэхтэй холбогдуулж үнэлгээг хийж, тайлагнах ажлын хэсэг өнгөрсөн дөрөвдүгээр сард байгуулагдсан. Үнэлгээг Дэлхийн банкны аргачлалаар нийт 10 модуль буюу салбар, чиглэлийн хүрээнд хийсэн ба Санхүүгийн зохицуулах хороо өөрийн зохицуулалттай 6 салбарын модулийн үнэлгээг нийт 82 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр хийж ажиллалаа. Үндэсний эрсдэлийн үнэлгээний ажлын хэсэгт мэргэжлийн холбоод, зохицуулалттай салбаруудын төлөөллийг хамруулж холбогдох статистик, тоо мэдээг олон төрлийн эх үүсвэрээс цуглуулж, баталгаажуулж ажилласнаараа онцлогтой.

Үндэсний эрсдэлийн үнэлгээний хэлэлцүүлгийг 2020 оны 10 дугаар сарын 26–29-ний өдрүүдэд холбогдох төрийн байгууллагуудын болон Хорооны зохицуулалттай байгууллагуудын төлөөлөл болох 120 гаруй оролцогч модуль 4 /үнэт цаасны салбар/, модуль 5 /даатгалын салбар/, модуль 6А /банк бус санхүүгийн байгууллагын салбар/, модуль 6Б /хадгаламж, зээлийн хоршоодын салбар/, модуль 7 /үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын салбар/, модуль 7 /үнэт металл, үнэт чулуу эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчдийн салбар/, модуль 9 /санхүүгийн хүртээмжтэй бүтээгдэхүүн/-ийн хүрээнд зохион байгууллаа.

Хэлэлцүүлгийн үеэр төрийн болон төрийн бус байгууллагуудын гаргасан саналыг үнэлгээний тайланд тусгаж, Дэлхийн банкны саналыг авснаар салбаруудын эрсдэлийн үр дүнг эцэслэн,

үнэлгээний тайланг холбогдох байгууллагуудад хүргүүлэн ажиллана.

Монгол Улс 2020 оны 10 дугаар сарын 23-ны өдөр ФАТФ-ын стратегийн дутагдалтай орнуудын жагсаалт буюу “Саарал жагсаалт”-аас гарсан ч үр дүнтэй тогтолцоог хэвээр хадгалж үлдэх, олон улсын стандартыг үргэлжлүүлэхэд энэ удаагийн үндэсний эрсдэлийн үнэлгээ нь чухал ач холбогдолтой. Мөн Санхүүгийн болон санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчдийн салбарт тулгарч буй эрсдэлийг тодорхойлж, илэрсэн эрсдэлийг бууруулах чиглэлээр стратеги боловсруулах нь ФАТФ-ын дараагийн буюу 2023 онд хийгдэх үнэлгээнд бэлтгэх ажлын нэг хэсэг болох юм.

### ИПОТЕКИЙН ДААТГАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ГАРЦ ШИЙДЛИЙГ ТОДОРХОЙЛОХ АЖЛЫН ХЭСЭГ БАЙГУУЛАГДЛАА

Засгийн газрын 2018 оны 369 дүгээр тогтоолоор баталсан “Орон сууцны хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтийн журам”-ын 4.2.9, Монголбанкны ерөнхийлөгчийн 2008 оны 446 тоот тушаалаар баталсан “Ипотекийн зээлийн үйл ажиллагааны журам”-ын 22.2-т зээлдэгч нь ипотекийн зээл авахдаа хөрөнгийн болон зээлдэгчийн амь насны даатгалд зээлийн үүргийн гүйцэтгэл дуусах хүртэлх хугацаанд заавал хамрагдсан байхаар зохицуулсан билээ.

Хууль тогтоомж, салбарын нөхцөл байдлыг харгалзан үзэж тус Хорооноос 2017 оны 109, 2018 оны 210 дугаар тогтоолоор “Ипотекийн даатгалын үйл ажиллагааны журам”-ыг баталж,

ипотекийн даатгалын үнэлгээ, хураамж, нөхөн төлбөр тооцоолох аргачлалыг тодорхой болгож, зээлдэгчийн амь насны даатгалын хүрээнд ердийн даатгагчийн хувьд гэнэтийн ослын улмаас, урт хугацааны даатгагчийн хувьд аливаа шалтгааны улмаас даатгуулагч нас барах болон хөдөлмөрийн чадвараа 70 буюу түүнээс дээш хувиар алдах эрсдэлийг даатгахаар зохицуулж, даатгуулагч-зээлдэгчийн өөрсдийн сонголтоор даатгалын эрсдэл, даатгалын компани сонгох боломжийг бүрдүүлж, уг даатгалын бүтээгдэхүүнийг бүртгэх, хянах зохицуулалтыг бий болгосон.

Гэвч иргэдийн төлбөрийн чадварын байдал, эрсдэлийн удирдлага болон даатгалын талаарх мэдлэг ойлголтгүйгээс хамаарч даатгалын хураамжийн төлөлт тасалдаж гэрээний сунгалт хийгдэхгүй байх, даатгуулагч гэнэтийн осол эсхүл аливаа шалтгааны улмаас нас барах – аль эрсдэлээс хамгаалагдаж даатгуулснаа мэдэхгүй байх зэрэг асуудлууд үүсэж байна.

Тухайлбал, 2019 оны жилийн эцсийн байдлаар ипотекийн зээлийн багцад эзлэх даатгалын гэрээний хугацаа нь хүчинтэй зээлийн хувь зээлдэгчийн амь нас, эрүүл мэндийн даатгалын хувьд 51.34%, эд хөрөнгийн даатгалын хувьд 50.83% байгаа бөгөөд амь нас, эрүүл мэндийн даатгалд даатгуулсан зээлдэгчид 100% ердийн буюу гэнэтийн ослын улмаас учрах эрсдэлээс хамгаалагдсан болно. Мөн Санхүүгийн зохицуулах хороонд 2017 оноос 2020 оны 2 дугаар улирлыг дуустал хугацаанд ипотекийн даатгалтай холбогдох 77 өргөдөл гомдол ирсний 64 нь зээлдэгчийн амь насны, 11 нь барьцаа хөрөнгийн даатгалтай, 2 нь даатгагч болон зуучлагч банкны үйл ажиллагаатай холбоотой байв.

Энэ нь зээлдэгчийн амь нас, эрүүл мэнд өвчний улмаас хохирсон тохиолдолд даатгалын хамгаалалт огт байхгүй, өндөр дүнтэй зээл төлөх эсхүл орон байргүй болох, иргэд даатгалын талаар буруу ташаа ойлголттой болох, мөн түүнчлэн ипотекийн зээл, даатгалын үйл ажиллагаа зөв зохистой явагдахгүй байх зэрэг олон эрсдэлийг дагуулж байгаа юм.

Түүнчлэн Ипотекийн барьцаа хөрөнгийн даатгалын эрсдэлд гамшгийн буюу газар хөдлөлт ордоггүй бөгөөд томоохон хэмжээний байгалийн гамшиг тохиолдоход зээл олгогч болон зээлдэгч талууд аль аль нь санхүүгийн томоохон хүндрэлд орж, улмаар ипотекийн зах зээл бүхэлдээ буюу системийн хэмжээний гарз хохирол учрахад түүнийг бууруулах, удирдах арга зам тодорхойгүй байна.



Иймд Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2020 оны 354 дүгээр тушаалаар “Ипотекийн даатгалын үйл ажиллагааны өнөөгийн нөхцөл байдал, тулгамдаж буй асуудал, тэдгээрийг шийдвэрлэх гарц шийдлийг тодорхойлох, санал дүгнэлт боловсруулах” чиг үүргийг хэрэгжүүлэх Санхүүгийн зохицуулах хороо, Монголбанк, Даатгалын холбоо, Монголын банкны холбоо, “Нэйшнл лайф даатгал” ХХК болон “МИК ОССК” ХХК-ийн төлөөллүүд оролцсон ажлын хэсэг байгуулагдлаа.

### ДААТГАЛЫН КОМПАНИУДЫН ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ ДЭХ ОРОЛЦООГ НЭМЭГДҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР ОЛОН НИЙТЭЭС САНАЛ АВЧ ЭХЭЛЛЭЭ

Улсын Их Хурлын 2017 оны 299 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Монгол Улсын санхүүгийн зах зээлийг 2025 он хүртэл хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”, мөн Улсын Их Хурлын 2020 оны 21 дүгээр тогтоолоор баталсан “Зээлийн хүүг бууруулах стратеги”-д тусгагдсан чиглэл, арга хэмжээнд үндэслэн олон улсын даатгалын компаниудын хөрөнгийн зах зээл дэх оролцоо, туршлага, стандарт, даатгалын салбарын өнөөгийн нөхцөл байдлыг судалж, даатгалын компаниудын үндсэн үйл ажиллагааны нэг болох хөрөнгө оруулалтын удирдлагыг зөв зохистой, оновчтой хэлбэрээр хэрэгжүүлж олон улсын жишигт нийцүүлэх, хөрөнгийн зах зээлийг дэмжих, даатгагчийн хөрөнгийг олон талт хөрөнгө оруулалтад байршуулах, эрсдэлийг тархах зорилгоор Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Даатгалын багц дүрэм”-ийн хоёрдугаар хавсралт “Даатгагчийн төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлт, түүнд хяналт тавих журам” болон дөрөвдүгээр хавсралт “Даатгалын нөөц санд болон албан журмын даатгалын санд төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээ, түүнийг хөрөнгө оруулалтад байршуулахад тавигдах нөхцөл, шаардлага”-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Хорооны тогтоолын төслийг боловсруулж, тус төсөлд даатгалын компаниуд, холбогдох байгууллага болон олон нийтээс санал аван ажиллаж байна.

### ДААТГАГЧИЙН ДАВХАР ДААТГАЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨНД ТАВИГДАХ ШААРДЛАГЫН ШИНЭЧИЛСЭН ХУВИЛБАРЫГ БОЛОВСРУУЛЛАА

Давхар даатгалын төлөвлөгөөнд тавигдах зохицуулалтын үр ашгийг нэмэгдүүлэх, олон улсын жишигт нийцүүлэх зорилгоор Олон Улсын даатгалын хянан шалгагчдын холбоо /IAIS/-оос боловсруулсан ICP 13 /Даатгалын тулгуур зарчим 13/ “Давхар даатгал болон эрсдэл шилжүүлгийн бусад хэлбэрүүд” /Reinsurance and other forms of risk transfer/-ийг судалж, уг зарчимд үндэслэн давхар даатгалын төлөвлөгөөнд тавигдах шаардлага, түүнийг тайлагнах, хянах үйл ажиллагааг зохицуулсан журам болох “Даатгалын багц дүрэм”-ийн арван гуравдугаар хавсралт “Даатгагчийн давхар даатгалын төлөвлөгөөнд тавигдах шаардлага”-ыг шинэчлэн боловсрууллаа.

Энэ хүрээнд давхар даатгалын төлөвлөгөөг боловсруулахад даатгагчийн эрсдэлийн удирдлагын нэгж болон төлөөлөн удирдах зөвлөлийн хүлээх үүрэг, хариуцлага, давхар даатгалын үйл ажиллагааны улмаас даатгагчид учирч болзошгүй эрсдлүүд болон найдвартай хэвийн үйл ажиллагаа бүхий давхар даатгагчийг сонгох шалгуур үзүүлэлт зэргийг нарийвчлан тусгасан бөгөөд даатгагчийн давхар даатгалын үйл ажиллагааны удирдлага, хяналт, хэрэгжилт нь үр дүнтэй, зохистой явагдах нөхцөл бүрдэнэ гэж үзэж байна.

## БАЙР СУУРЬ

## МАНАЙ УЛСЫН ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛД ӨРГӨЖИХ БОЛОМЖ БИЙ

*Манай улсын даатгалын зах зээлийн нэвтрэлт, нягтрал нь хөгжиж буй улс орнуудын дунджаас 6 болон 8 дахин бага байгаа нь энэ хэмжээгээр манай улсын даатгалын зах зээл өргөжих, хөгжих боломж байгааг илтгэж байгаа юм.*

**Даатгалын салбарын өнөөгийн байдал, цаашдын хөгжлийн чиг хандлагын талаар Санхүүгийн зохицуулах хорооны Даатгалын газрын дарга З.Батболдтой ярилцлаа.**

Тус салбарыг хөгжүүлэхэд олон тулгуурт даатгалын тогтолцоог бий болгох буюу урт хугацааны болон давхар даатгалыг бодлогоор дэмжин хөгжүүлэх, даатгалын компаниудын хөрөнгийн зах зээл дээрх оролцоог нэмэгдүүлэх, иргэд олон нийтийн даатгалын талаарх мэдлэг ойлголтыг сайжруулах, даатгалын бүтээгдэхүүн, үйлчилгээг дэвшилтэт техник технологи ашиглан хүртээмжтэй хүргэх, даатгалын мэдээллийн нэгдсэн сан бий болгох зэргээс гадна нэн тэргүүнд даатгалын компаниудын хүний нөөц, боловсон хүчний мэргэшсэн байдлыг нэмэгдүүлэх, зохистой засаглал, ёс зүйтэй үйл ажиллагааг дэмжин хөгжүүлэх зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.

**Даатгалын хамрагдалтыг нэмэгдүүлэхэд даатгалын үйл ажиллагааг ёс зүйтэй явуулах нь чухал ач холбогдолтой юу? Санхүүгийн зохицуулах хороо энэ хүрээнд зохицуулалтын ямар арга хэмжээ авч байна вэ?**

Тийм, санхүүгийн үйл ажиллагаа нь итгэлцэл дээр тогтдог, тэр дундаа даатгалын үйл ажиллагааг илүү ёс зүйтэй, зарчимд суурилан явуулах нь зүйтэй бөгөөд даатгуулагчдын итгэлийг дааж, түүнийг хэвийн зохистой явуулснаар нийгэмд асар их дэмжлэг үзүүлдэг. Энэ үүднээс Хорооны 2020 оны 114 дүгээр тогтоолоор “Даатгалын зах зээлийн ёс зүйн журам”-ыг баталсан бөгөөд энэ хүрээнд даатгалын зах зээлд оролцогч бүр ёс зүйн дүрэмтэй болж, мөрдөж хэвших, хариуцлага тооцох тогтолцоо бүрдэх юм. Ингэснээр даатгалын зах зээлд оролцогчдын үйл ажиллагаа илүү ёс зүйтэй, шударга өрсөлдөөнтэй явагдах боломж бүрдэж, даатгуулагч олон нийтийн даатгалд итгэх итгэл нэмэгдэн даатгалын хамрагдалт өсөх

ач холбогдолтой юм.

Мөн улс орон, хүний амьдралын алхам тутамд аливаа эрсдэлд өртөх магадлал байсаар байдаг, энэхүү үүсэж болзошгүй эрсдэлийг бусдад бага зардлаар шилжүүлснээр ирээдүйд гарах эдийн засаг, санхүүгийн хохирлоос хамгаалагддаг. Нөгөөтэйгүүр даатгалын компаниуд эрсдэлийг өөрт шилжүүлэн авсны төлбөр болох хураамжийн орлогоор нөөц сан бүрдүүлэн, түүгээр бусад салбаруудад хөрөнгө оруулалт хийснээр нийгэмд зөв мөнгөн урсгал, тогтолцоо бий болдог.

Иймд даатгалын салбарын зохицуулагч байгууллагын хувьд Санхүүгийн зохицуулах хороо нь тус салбарын мэргэшсэн байдал, компанийн засаглал, технологид суурилсан олон нийтэд хүртээмжтэй бүтээгдэхүүн, үйлчилгээ, даатгуулагчдын эрх ашгийг хамгаалсан зохицуулалтуудыг сайжруулах зорилгоор Улсын Их Хурал болон Засгийн газраас баталсан бодлого, стратегийн баримт бичгүүдэд тусгагдсан арга хэмжээ, Олон улсын даатгалын хянан шалгагчдын холбооноос боловсруулсан Даатгалын тулгуур зарчим (ICP), зөвлөмжид тулгуурлан гадаад улс орнуудын зохицуулалтын орчин, сайн туршлага, салбарын үйл ажиллагаанд тулгамдаж буй асуудлуудыг судалж холбогдох журмуудад өөрчлөлт оруулахаар ажиллаж байна.

Мөн Хороо нь хуулиар олгосон эрх, үүргийн хүрээнд Олон улсын зохицуулалтын байгууллагуудын бодлого, зохицуулалтын орчин болон дотоодын даатгалын зах зээлийн хөгжил дэвшил, хурдтай нь нийцүүлэн тухай бүр холбогдох журам, заавруудыг шинэчлэн боловсруулах, сайжруулах тал дээр анхаарч ажиллаж байгаа ба иргэдийн дундах даатгалын тухай ойлголт, санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх хүрээнд холбогдох төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтын ажиллагаагаа өргөжүүлэн ажиллаж байна.

**Даатгалын салбарын хууль эрх зүйн орчин, ирээдүйд хийгдэхээр төлөвлөсөн томоохон өөрчлөлт шинэчлэлтийн талаар дурдвал?**

Манай улсад арилжааны даатгалын үйл ажиллагаанд холбогдох Иргэний хууль (даатгалын гэрээний харилцаа), Даатгалын тухай хууль, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль, Жолоочийн даатгалын тухай хууль, Малын индексжүүлсэн даатгалын тухай хууль болон бусад даатгуулах талаарх заалт тусгагдсан 11 хууль хүчин төгөлдөр мөрдөгдөж байна. Санхүүгийн зохицуулах хороо нь дээрх хууль тогтоомжууд болон өөрийн хуулиар олгогдсон бүрэн эрхийн хүрээнд боловсруулан баталсан “Даатгалын багц дүрэм”, бусад холбогдох журам, зааврын хүрээнд даатгалын үйл ажиллагааг зохицуулж, хяналт тавин ажиллаж байгаа болно.

Даатгалын зах зээл хөгжихийн хэрээр салбарын хууль, эрх зүйн орчныг шинэчлэх, сайжруулах цаг үетэй нь нийцүүлэх шаардлага үүсэж байна. Иймд Монгол Улсын Их Хурлын 2016 оны 19 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”, мөн “Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл батлах тухай”, Улсын Их Хурлын 2017 оны 11 дүгээр тогтоолын хавсралтын 80, 81, 83-т “Даатгалын тухай, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай, Жолоочийн даатгалын тухай хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулж даатгалын салбарын өнөөгийн байдал, хөгжлийн хандлага, зах зээлийн эрэлт, хэрэгцээнд нийцүүлэн уг зах зээлд гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих, даатгалын нэр төрөл, бүтээгдэхүүний ангилал, тэдгээртэй холбоотой зохицуулалтыг нарийвчлан тусгах” гэж заасан. 2018 оноос салбарын тулгуур болох дээрх 3 хуулийг шинэчлэхээр Сангийн яам, Санхүүгийн зохицуулах хороо болон бусад холбогдох мэргэжлийн байгууллагууд хамтарсан ажлын хэсэг байгуулан ажилласан бөгөөд одоогийн байдлаар шинэчилсэн найруулга, нэмэлт, өөрчлөлтийн хуулийн төслийн үзэл баримтлал батлагдаад байгаа юм.

Хороо нь хувийн тэтгэврийн даатгалын тогтолцоо болон санхүүгийн салбарт шинэчлэлтийг авч ирэх “Хувийн нэмэлт тэтгэврийн тухай”, “Хувийн тэтгэврийн тухай” хуулийн төслүүдийг харьцуулан судалж, холбогдох саналуудыг хүргүүлэн ажиллаж байгаа бөгөөд мөн санхүүгийн боловсрол, санхүүгийн омбудсмен, мөнгө хүүлэлтийн эсрэг арга хэмжээ, санхүүгийн үйлчилгээнд тавигдах шаардлага ба мэдээллийн ил тод байдал, нууцлал зэрэг харилцааг зохицуулсан Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн төслийг боловсруулах ажлын хэсэгт орж ажиллаж байна.

Түүнчлэн Монгол Улсын Их Хурлын 2020 оны 21 дүгээр тогтоолоор баталсан “Зээлийн хүүг бууруулах стратеги”-д тусгагдсан “Банк, санхүүгийн салбарт санхүүгийн технологи, цахим шилжилтийг эрчимжүүлэн үр ашгийг нэмэгдүүлэх” арга хэмжээний хүрээнд тус Хороо нь даатгалын гэрээ, хэлцлийг цахимаар хийж, баталгаажуулах зорилгоор холбогдох хуулиудад нэмэлт өөрчлөлт оруулах санал боловсруулж байгаа болно.

#### **Даатгалын салбар дахь цахимжуулалт, дэвшилтэт технологийн ач холбогдлыг товчоор хэлж өгөхгүй юу?**

Олон улсын санхүүгийн салбарт технологийн дэвшлийг ашигласан бүтээгдэхүүн, үйлчилгээ ихээр нэмэгдэж, үүнийг дагаад технологийн салбарт оруулах хөрөнгө оруулалт тогтмол өсөж байна. Даатгалын салбар нь уг дэвшилтэт технологи хамгийн ихээр хэрэгцээтэй салбарын нэг юм. Жишээлбэл, даатгалын гэрээ байгуулах, даатгалын тохиолдлыг баталгаажуулахад технологийн дэвшлийг ашигласнаар хэрэглэгч, даатгуулагчдад салбарын бүтээгдэхүүн, үйлчилгээ илүү хялбар, ойр болох, зардал хэмнэх, улмаар эдгээр үйлчилгээнээс гарах мэдээллүүдийг төвлөрүүлэх, хуваарилах, ашиглах зохицуулалт бүхий мэдээллийн нэгдсэн сан бий болж, эрсдэлийг илүү нарийвчлан үнэлэх боломж бүрдэх ба хамгийн гол нь даатгалын бүтээгдэхүүн, үйлчилгээ түргэн шуурхай, хүртээмжтэйгээр иргэн, аж ахуйн нэгжид хүрэх болно.

Мөн дэлхий дахинд тархаад буй шинэ төрлийн корона вируст цар тахлаас олон нийтийг хамгаалахын тулд санхүүгийн салбарын бүтээгдэхүүн, үйлчилгээг цахимжуулах, технологижуулах зайлшгүй шаардлага бий болоод байна.

#### **Шинэ төрлийн корона вируст халдвар (Ковид-19)-ын цар тахал манай улсын даатгалын салбарт хэрхэн нөлөөлсөн бэ, үүсэж болзошгүй хүндрэлээс урьдчилан сэргийлэх ямар арга хэмжээнүүдийг Хорооны зүгээс хэрэгжүүлж ажилласан бэ?**

Цар тахал тус салбарт хэрхэн нөлөөлснийг 2020 оны эхний 3 улирлын байдлаар товч дүгнэн үзэхэд, санхүү, итгэлцэл, зээл, хариуцлагын даатгал зэрэг даатгуулагчийн бизнесийн үйл ажиллагааны тогтвортой байдал алдагдсантай холбогдох даатгалын бүтээгдэхүүнүүд болон гадаадад зорчигчийн гэнэтийн ослын даатгалтай холбогдох нөхөн төлбөрийн хэмжээ даатгагчийн тооцоолсноос давж, жолоочийн хариуцлага, тээврийн хэрэгслийн даатгалын тохиолдлын тоо өмнөх оны мөн үетэй харьцуулахад 9.8 хувиар буурсан боловч гадаад валютын ханшийн өсөлт автомашины сэлбэг хэрэгслийн үнэд нөлөөлснөөр нөхөн төлбөрийн хэмжээ 2.3 хувиар өссөн. Харин ачааны даатгал, гадаад зорчигчийн гэнэтийн ослын даатгал зэрэг хил дамнан үйл ажиллагаанд холбогдох даатгалын бүтээгдэхүүнүүдийн хураамжийн орлого 2020 оны 2 дугаар улирлын байдлаар буураад байсан бол 3 дугаар улирлаас ачааны даатгалын борлуулалт өсөж, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 36.7 хувиар нэмэгдэж, тус даатгалын үйл ажиллагаа хэвийн явагдаж эхэлсэн байв.

Ковид-19 цар тахлаас үүдэн улсын хэмжээнд хөл хорио тогтоосонтой холбогдуулан энэ оны 2 дугаар сард Хорооноос нөхцөл байдлыг судалж, гадаадад зорчигчийн гэнэтийн осол, эрүүл мэндийн даатгал, нийтийн зорчигч тээврийн даатгал, гадаад, дотоод ачаа тээврийн даатгалын бүтээгдэхүүний борлуулалт зогсох, иргэд, аж ахуйн нэгжийн санхүүгийн чадамж буурснаар даатгалын хураамж төлөлт тасалдах, даатгалын нөхөн төлбөрийн зардал нэмэгдэх, компаниуд ажилтнуудаа халдвараас хамгаалж зайнаас ажиллуулах, ажлын цагийг багасгах зэргээс хамаарч даатгалын хураамжийн орлого буурах, үйл ажиллагааны тогтвортой байдал алдагдах гэх мэт олон сөрөг нөхцөл байдлууд үүсэж болзошгүй гэж таамаглаж байлаа.

Иймд дээрх таамаглалыг харгалзан үзэж Хороо нь 2020 оны 2 дугаар сарын 29-ний өдрөөс Үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангах, төлбөрийн чадвар, хөрвөх чадварын эрсдэлийг бууруулах, даатгуулагчдын эрх

ашгийг хамгаалах гэсэн үндсэн 3 чиглэлээр мэргэжлийн холбоодтой хамтран даатгалын мэргэжлийн оролцогчийн эрх олгох сургалт, шалгалт, семинар зэргийг онлайн хэлбэрт шилжүүлж ажиллах, Хорооны бүртгэл, зөвшөөрлийн цахим системийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, цахим дэвшилтэт технологи ашиглалт, цар тахалтай холбогдох шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ нэвтрүүлэхийг дэмжих зэрэг 8 арга хэмжээг бодлого, зохицуулалтын хүрээнд авч хэрэгжүүлсэн.

#### **Корона вируст халдвар (Ковид-19)-тай холбоотой ямар даатгалын бүтээгдэхүүнүүд бүртгэлтэй байгаа вэ?**

Сүүлд буюу Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдалд шилжсэн үед нийт иргэд, даатгуулагчдад зориулсан “Ковид-19” эрүүл мэндийн даатгалын бүтээгдэхүүнийг “Нэйшнл лайф даатгал” ХХК-аас боловсруулж ирүүлснийг Санхүүгийн зохицуулах хороо цахимаар хянаж, 11 дүгээр сарын 24-ний өдөр бүртгэсэн. Ингэснээр иргэд, даатгуулагчид тус вирусын улмаас учирч болзошгүй санхүүгийн эрсдэлээс хамгаалагдах боломж бүрдэж байгаа юм. “Нэйшнл лайф даатгал” ХХК-аас нийгмийн хариуцлагынхаа хүрээнд энэ оны 4 дүгээр сарын 8-ны өдөр 9 дүгээр сар хүртэл хэрэгжсэн “Ковид-19 амь нас, хөдөлмөрийн чадвар алдалтын даатгал”-ын бүтээгдэхүүнийг Хороонд бүртгүүлж, цар тахлын халдварын эрсдэлтэй нөхцөлд ажиллаж буй төрийн тусгай албан хаагчийг үнэ төлбөргүй даатган ажиллаж байна.

Түүнчлэн “Мандал Даатгал” ХК нь 2020 оны 5 дугаар сард Ковид хүртээмжтэй даатгалыг Хороонд бүртгүүлэн өөрийн харилцагч 82,000 даатгуулагчдаа үнэ төлбөргүй даатгалд хамруулж ажилласан ба бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан уг бүтээгдэхүүнийг шинэчлэн, фейсбүүкийн чатботоор дамжуулан борлуулж байна.

Дотоодод уг корона вирус илэрч, хөл хорио тогтоосноос хойш даатгалын бүх компани утсаар болон фейсбүүк мессенжер буюу чатбот ашиглан, 5 даатгалын компани эдгээрээс гадна цахим болон гар утасны аппликейшн ашиглан зөвлөгөө өгөх, даатгалын тохиолдлын талаарх мэдээлэл болон нөхөн төлбөрийн баримт материалыг хүлээн авах зэргээр даатгалын үйлчилгээг иргэд, даатгуулагчдад цахимаар хүргэн, үйл ажиллагаагаа хэвийн явуулж байгаа болно.

## ТАЙЛБАР БА ЗӨВЛӨМЖ

### ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛИЙН ЁС ЗҮЙН ЖУРАМ

Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 114 дүгээр тогтоолоор баталсан “Даатгалын зах зээлийн ёс журам” нь даатгалын зах зээлд оролцогчдоос хууль, шударга ёсыг дээдлэх, ил тод байх, даатгуулагч, даатгалын тохиолдлын хохирогчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх, даатгуулагчид

шуурхай үйлчлэх, шударга өрсөлдөөнийг эрхэмлэх, даатгалын зах зээлд оролцогчийн эрх ашиг, нэр хүндэд хүндэтгэлтэй хандах, даатгалын салбарын мэргэжлийн нэр хүндийг эрхэмлэх, дээшлүүлэх гэсэн үндсэн 7 зарчмын хүрээнд холбогдох шаардлагуудыг тусгасан эрх зүйн акт юм.

Мөн энэхүү журмаар даатгалын зах зээлд оролцогчдыг тодорхойлж, зах зээлд оролцогч бүр ёс зүйн дүрэмтэй байх шаардлагыг тусгаж, шат дараалсан хяналтын тогтолцоо бүхий зохицуулалтыг бий болгосон. Дурдвал:

#### 1. Даатгалын зах зээлд оролцогчдыг тодорхойлох:

- Даатгалын салбарт үйл ажиллагаа явуулж буй хувь хүн /даатгалын төлөөлөгч, аудитор, актуарч/;
- Хуулийн этгээд, тэдгээрийн ажилтнууд /даатгагч, даатгалын зуучлагч, хохирол үнэлэгч, даатгалын байгууллагад аудит хийх эрх бүхий аудитын байгууллага, мэргэжлийн холбоод/;
- Хувьцаа эзэмшигчид.

#### 2. Зах зээлд оролцогч бүр ёс зүйн дүрэмтэй байх:

Даатгалын зах зээлд оролцогч хуулийн этгээдүүд нь уг журамд нийцүүлэн өөрийн байгууллагын чиг үүрэг, үйл ажиллагааны цар хүрээ, онцлогийг харгалзан ёс зүйн дүрэм, журмыг батлан мөрдүүлэхээр тусгасан болно. Тухайн байгууллага нь өөрийн дотоодын мэргэжлийн ёс зүйн дүрмийн хэрэгжилт, хариуцлага тооцохтой холбоотой харилцааг зохицуулах нөхцөлийг бүрдүүлсэн байхаар заасан.

#### 3. Хянах, хариуцлага тооцох үйл ажиллагааг тодорхойлсон:

Даатгалын зах зээлийн ёс зүйн хэм хэмжээ зөрчсөн тухай иргэд, байгууллага, аж ахуйн нэгжээс Хороонд ирүүлсэн гомдол, мэдээлэл, эсхүл хэвлэл, мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн сүлжээнд энэ талаар нийтлэгдсэн бол Хорооноос хууль тогтоомжийн дагуу хяналт тавина. Даатгалын зах зээлд оролцогч нь Хорооны хяналт шалгалтаар болон тухайн байгууллагын дотоод хяналтаар илэрсэн мэдээ, баримтаар Даатгалын зах зээлийн ёс зүйн журам болон өөрийн байгууллагын ёс зүйн дүрмийг дагаж мөрдөөгүй нь нотлогдсон тохиолдолд хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэхээр журамд тусгасан.



## ФИНТЕК БА РЕГТЕК

### ДААТГАЛЫН САЛБАРЫН ТЕХНОЛОГИД СУУРИЛСАН САНХҮҮГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

Финтек (Fintech – financial technology) нь англиар санхүүгийн технологи гэсэн 2 үгийн нийлмэл товчлол бөгөөд ерөнхийдөө орчин үеийн техник технологийн дэвшилд тулгуурлан санхүүгийн үйлчилгээг нэвтрүүлэх зорилготойгоор үүссэн ойлголт юм. Технологийн хурдацтай хөгжлийг дагаад банк, санхүүгийн байгууллагууд ч өөрсдийн бүтээгдэхүүн, үйлчилгээндээ технологийн дэвшлийг өргөнөөр ашиглаж байна. Үндэстэн дамнасан корпораци болох “Ernst & Young” компаниас 2015 оноос эхлэн финтекийн ашиглалтын үзүүлэлтийг (Fintech Adoption Index) тооцон гаргаж байгаа бөгөөд энэ үзүүлэлт нь 2017 оноос 2019 оны хооронд 33 хувиас 64 хувь болтлоо өссөнөөр дэлхий даяар финтекийн тархалт болон түүнийг хэрэглэгчдийн тоо хурдацтайгаар нэмэгдэж байгааг харуулж байгаа юм. Үүнтэй холбоотойгоор даатгалын салбарт ч мөн адил технологид суурилсан бүтээгдэхүүн, үйлчилгээ хурдацтай хөгжиж байна.



Даатгалын салбарт ашиглагдаж буй технологид суурилсан бүтээгдэхүүн үйлчилгээг Олон улсад “Иншүртек (Insurtech)” гэж томъёолох болсон бөгөөд энэ нь финтекийн нэг төрөл юм. Олон улсын шинжээчид даатгалын салбарыг шинэ технологи хамгийн их хэрэгцээтэй салбар гэж үзэж байна. Ковид-19 цар тахлын нөлөөгөөр Дэлхийн хэмжээнд ажилгүйдэл асар ихээр нэмэгдэж, ДНБ буурч, хөрөнгийн зах зээл тогтворгүй байсан хэдий ч технологид суурилсан бүтээгдэхүүн, үйлчилгээ, түүний зах зээлийн талаар голлон судалдаг “Venture Scanner” олон улсын судалгааны компанийн мэдээлснээр 2020 оны зөвхөн эхний хагас жилд иншүртекд оруулах нийт хөрөнгө оруулалт 2.2 тэрбум ам.долларт хүрч, 2017, 2018 онд бүтэн жилийн хугацаанд тухайн салбарт оруулсан нийт хөрөнгө оруулалттай бараг ижил түвшинд хүрсэн байна. /Зураг 1/

Зураг 1. Иншүртекийн санхүүжилтийн хандлага (2013–2020)



Эх сурвалж: Deloitte company

Дээрх тоон мэдээллээс харахад иншүртекд оруулж буй хөрөнгө оруулалт 2013 оноос хойш их хэмжээгээр өссөн ба даатгалын бүтээгдэхүүн, үйлчилгээнд технологийн дэвшлийг ашиглах байдал хурдацтайгаар нэмэгдсэн байна.

Иншүртек нь даатгалын үйл ажиллагааг илүү үр дүнтэй, даатгагчид даатгуулагчидтай харилцах, хамтран ажиллах дижитал арга замыг бий болгодог. Ерөнхийдөө иншүртек нь даатгалын зах зээлд оролцогчдод тулгамдаж буй асуудлуудыг хялбар, хэмнэлттэй арга замаар шийдэх боломжийг бүрдүүлж байгаа юм. Тухайлбал:

**Зардал хэмнэлт:** Дижитал даатгагчид уламжлалт загвараар үйл ажиллагаагаа явуулж буй даатгалын компаниудтай харьцуулахад илүү өрсөлдөх чадвар сайтай байна. Жишээлбэл, тусгайлсан нисдэг дрон ашиглан том хэмжээний агуулах, тариалангийн талбай, хүн очиж өөрийн биеэр үзэх боломжгүй газар зэргийг камерийн тусламжтайгаар тухайн орчны зургийг авч хохирлын хэмжээг тогтооход ашигладаг. Даатгалын нөхөн төлбөрийг тооцоолох үйл явцад дрон ашигласнаар үйл ажиллагааг зардал багатай, түргэн шуурхай болгож байна.



Нэхэмжлэлийн менежментийн програм хангамж /Зураг 2/-ийг ашиглан нөхөн төлбөрийн нэхэмжлэл гаргах, мөн даатгалын гэрээг цахимаар байгуулсанаар хүн хоорондын харилцааны үйл явцыг багасгаж, улмаар нөхөн төлбөрийг нэхэмжлэх болон түүнийг шийдвэрлэх үйл явцыг илүү хялбаршуулж, түүнд зарцуулагдах хугацааг богиносгох зэрэг давуу талыг үүсгэдэг.

Зураг 2. Эрүүл мэндийн даатгалын нэхэмжлэлийн менежмент



#### Ямар нэгэн нэмүү өртөггүйгээр ажил үүргийг автоматжуулах.

Даатгалын компаниуд нь хүний хийх үйл ажиллагааг автоматжуулснаар хөдөлмөрийн зардлыг бууруулах боломжтой бөгөөд “BCG” олон усын зөвлөх үйлчилгээ үзүүлдэг компаниас мэдээлж буйгаар үсрэнгүй технологийн дэвшил даатгалын хураамжийн зардлыг /premium cost/ 10 хувь хүртэл, нөхөн төлбөрийн зардлыг 8 хувь хүртэл бууруулдаг байна. Блокчейн технологи нь хүний үйл ажиллагааг технологиор орлуулан ажил үүргийг автоматжуулж байна. Үүний нэг жишээ бол ухаалаг гэрээ ашиглан хийгдэж буй аялалын даатгал юм. Олон улсад даатгалын үйл ажиллагаа явуулдаг “АХА” даатгалын компани нь аялалын даатгалын бүтээгдэхүүн, үйлчилгээндээ ухаалаг гэрээг ашиглаж эхлээд байгаа юм. Тус ухаалаг гэрээ, төлбөр тооцооны систем нь тухайн даатгуулагчийн зорчиж буй агаарын тээвэр нь даатгалын гэрээнд заасан хугацаанаас илүү хугацаагаар хоцорсон эсэхийг шалгаж автоматаар нөхөн төлбөрийг олгодог. Нөхөн төлбөрийн хэмжээ харьцангуй бага, хугацаа их шаарддаг энэ төрлийн даатгалын тохиолдлууд нь даатгалын компаниудын нэр хүндийг унагаж, үйлчлүүлэгчдээ алдахад хүргэдэг. Ийнхүү ухаалаг гэрээний тусламжтайгаар дээрх эрсдэлүүдийг бууруулж байна.

**Илүү нарийвчилсан эрсдэлийн үнэлгээ.** Даатгалын үйл ажиллагаа нь хэрэглэгчийн талаарх маш олон тооны хүчин зүйлсийн тоон өгөгдөл болон статистик дээр суурилан хийгддэг бизнес юм. Гэвч салбарын хувьд бодит цагийн өгөгдөл бус түүхэн өгөгдөл дээр суурилсан шинжилгээ хийгдсээр байна. Харин дижитал технологи нь асар том хэмжээний бодит цагийн өгөгдлийн урсгалыг бий болгож, үйлчлүүлэгч тус бүрийн хувийн мэдээллийн сан бүрдүүлэх боломжийг бий болгож байна. Энэ нь илүү сайн эрсдэлийн үнэлгээ хийх боломжийг олгож байгаагаас гадна бидэнд өдөр тутам эрүүл мэнд болон амьдралын хэв маягаа хянах, жолоочийн туслах зэрэг үйлчилгээг давхар авах боломжийг олгож байна. Эдгээр шинэ технологиудын томоохон төлөөллүүд бол ухаалаг байшин болон квантын тооцоолол юм. Ухаалаг байшингийн хувьд байшингийн эргэн тойрон дахь дижитал мэдрэгч нь байшингийн талаарх мэдээллийг оршин суугчдад цаг тухай бүрд нь өгснөөр болзошгүй эрсдэлээс хамгаалж болох бөгөөд ингэснээр даатгагчид бага зардал гаргаж, үйлчлүүлэгчид бага шимтгэл төлөх боломж бүрдэж байгаа юм. Түүнчлэн ухаалаг


байшингийн технологиуд нь тухайн харилцагчийн дадал зуршилд үндэслэн хэрэглэгчийн танилцуулгыг бий болгож, андеррайтингийн үйл ажиллагаа үнэн зөв, бодитой болох боломжийг бүрдүүлж байна.

Өөр нэг томоохон нээлт хийхээр ажиллаж буй технологи бол квантын тооцоолол юм. Даатгалын салбар дахь ярвигтай тооцооллын үр дүнг гаргахын тулд квантын тооцооллыг ашиглахаар хэдийнээ даатгалын компаниуд туршиж эхлээд байна.



**Илүү хялбар хэрэглээ.** Жил бүр даатгалын компаниуд хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээний талаарх мэдээлэл цуглуулж, түүний тайлагналын стандартыг бий болгох, улмаар хэрэглэгчдийн шийдвэр гаргах үйл явцад дэмжлэг үзүүлэх зэрэгт маш их цаг хугацааг зарцуулдаг. Харин техник, технологийн дэвшлийн энэ үед даатгалын компаниуд үйлчлүүлэгч, даатгуулагчиддаа олон нийтийн цахим сүлжээ, чатбот, гар утасны аппликэйшн болон дуу хоолой таних алгоритм зэргийг ашиглан эдгээр төвөгтэй үйл ажиллагааг автоматжуулан, хялбарчилж, харилцагчдыг дэмжин, борлуулалттай холбогдох зардлаа эрс бууруулж байна.

Зураг 3. АНУ дахь Чатбот ашигласнаар үүссэн цалингийн зардлын жилийн хэмнэлт /2016 он, тэрбум ам.доллар/



Эх сурвалж: McKinsey Олон Улсын зөвлөх үйлчилгээний компани

Канадын Онтариод байрлах “Excalibur Insurance” даатгалын компани нь үйлчлүүлэгчидтэй харьцах автомат AI роботыг ашиглалтад оруулсан байна. Уг робот нь 7 хоногийн 24 цагийн турш компанийн цахим хуудас болон фейсбүүкээр дамжуулан даатгалын үйл ажиллагааны холбогдох мэдээллийг даатгуулагч, үйлчлүүлэгчдэд хүргэж, мөн даатгалын гэрээг байгуулж, нэхэмжлэл болон үйлчилгээний хүсэлтийг шийдвэрлэж чаддаг байна. Тус даатгалын компанийн үйлчлүүлэгчтэй харилцах төвд үйлчлүүлэгч, даатгуулагчаас утсаар дамжуулан ирүүлдэг хүсэлтийн 70 хувьд нь л хариулт өгч чаддаг байсан бол тус систем энэхүү асуудлыг шийдвэрлэх нэгэн гарц болсон. Түүнчлэн ухаалаг систем нь шинэчлэгдсэн мэдээлэл илгээх, агентуудад үүрэг даалгавар өгөх, үйлчлүүлэгчдээ хадгалж үлдэх үүднээс нөхөрсөг мэндчилгээ болон тусгай санал илгээх замаар тэдэнтэй халуун дулаан харилцаа үүсгэх зэрэг үйлдлүүдийг хийдэг байхаар программчлагдсан байна.

**Иншүртекийн цаашдын хандлага**

Дээрх шинэлэг технологийн шийдлүүдийг зах зээлд нэвтрүүлэхэд гол тулах хүч бол тухайн зах зээлд оруулж буй хөрөнгө оруулалт билээ. Иншүртект оруулж буй хөрөнгө оруулалт жил ирэх тусам өсөж байгаатай холбогдуулан даатгалын салбарт техник технологийн нээлтүүд бий болсоор байна. Үүнийгээ дагаад даатгалын салбар дахь Иншүртекийн эрэлт нэмэгдэж байгаа юм. Мөн энэ технологийн дэвшилд гол чухал нөлөөлж буй хүчин зүйл нь Ковид-19 цар тахал болсон бөгөөд цар тахлын хөл хориотой холбогдуулан даатгалын салбарт томоохон өөрчлөлтүүд орсон. Дижитал шинэчлэлт, өөрчлөлтийн энэ эрин үед хэрэглэгчдийн эрэлт, хэрэгцээ шаардлага ч мөн адил дижитал хэлбэрээр илэрхийлэгдэх болж, дээр дурдсан шинэлэг технологиуд нь даатгалын салбарын ирээдүйн өрсөлдөөнийг тодорхойлохоор байна.

Иймд олон улсад даатгалын компаниуд стратегийн хамтарсан капитал хөрөнгийг бий болгож, гарааны бизнесүүдэд стратегийн хамтарсан хөрөнгө оруулалт хийж байна. Зарим улс орнууд шинэлэг технологийг зах зээлд нэвтрэх боломжийг нэмэгдүүлэх “Сэндбокс зохицуулалт” болон “Зохицуулалтын хамгаалалтын арга” гэх мэт зохицуулалтын бодлогыг боловсруулсан бөгөөд энэ нь гарааны бизнесүүд өөрсдийн бизнес загварыг боловсруулахад дэмжин тусалдаг.

Иншүртекеэр дамжуулан хэрэглэгчдийн хэрэгцээг хэн түргэн шуурхай хангаж байна, тэр даатгалын компани зах зээлд дийлэнх хувийг эзлэх хандлага ажиглагдах боллоо. Иншүртект компаниуд даатгалын салбарт томоохон хувь нэмэр оруулж байгаа бөгөөд ялангуяа хөрөнгийн болон гэнэтийн ослийн даатгалд чухал нөлөө үзүүлж байна. Гэвч бусад санхүүгийн салбарт ашиглагдаж буй шинэлэг технологиудтай харьцуулахад иншүртект нь хоцрогдож яваа

бөгөөд цаашид амьдралын даатгалын бүтээгдэхүүн, үйлчилгээнд технологийн шинэлэг санаачлагуудыг хэрэгжүүлэх нэн шаардлагатай байгаа юм.

**Монгол Улсын даатгалын салбар дижитал эринд шилжих нь**

Сүүлийн жилүүдэд Монгол Улсын санхүүгийн зах зээлд технологид суурилсан санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээ хурдтай нэвтэрч, хэдхэн жилийн өмнөхтэй харьцуулахад банк, санхүүгийн үйлчилгээ бүхэлдээ цахимжиж, урьд өмнө нь санхүүгийн зах зээлд байгаагүй шинэ төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээ зах зээлд нэвтрэн, түүнийг дагасан хөрөнгө оруулалтын хэмжээ нэмэгдэж байна. Санхүүгийн зах зээл дэх энэхүү технологийн дэвшил, инноваци нь иргэд, олон нийтэд өөрийн хэрэгцээ, зан төлөвт тохирсон санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг орон зай, цаг хугацааны хязгаарлалтгүйгээр хүртэх боломжийг олгож байгаа билээ.

Манай даатгалын салбарын хувьд мөн адил технологид суурилсан шинэ төрлийн бүтээгдэхүүн үйлчилгээ өдрөөс өдөрт нэмэгдэж байгаа бөгөөд зарим даатгалын компаниуд даатгалын үйл ажиллагаандаа технологийн дэвшлийг ашиглаж даатгуулагч, үйлчлүүлэгчиддээ түргэн шуурхай үйлчлэх, үйл ажиллагааны зардлыг бууруулах, илүү нарийвчилсан эрсдэлийн үнэлгээ хийх зэрэг давуу талуудыг бий болгож байна.

Технологийн энэхүү хурдтай өөрчлөлтөд нийцсэн оновчтой зохицуулалтыг тухай бүр гаргаж, хэрэгжүүлэх нь зөвхөн манай улс орны хувьд ч гэлтгүй бусад олон улс орны бодлого зохицуулагчдад тулгамдаж буй асуудал болсон. Нөгөө талаас зах зээлд шинээр нэвтэрч буй финтекийн бүтээгдэхүүн, үйлчилгээнд тохиромжгүй зохицуулалтыг хэрэгжүүлэх нь салбарын хөгжлийг боомилох аюултай. Иймээс иншүртекийн бүтээгдэхүүн, үйлчилгээнд тохирсон зохицуулалтын орчныг бий болгох тал дээр Олон улсын санхүүгийн зохицуулах байгууллагууд зах зээлийг судалсан, ажигласан байр суурь баримталж байна.

Санхүүгийн зохицуулах хорооны хувьд ч мөн адил шаардлагатай судалгаануудыг тогтмол гүйцэтгэн ажиллаж байгаагаас гадна даатгалын салбарын өрсөлдөөн, хүртээмжийг нэмэгдүүлэх, технологид суурилсан бүтээгдэхүүн, үйлчилгээг дэмжих зорилгоор Хорооны 2019 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Даатгалын багц дүрэм”-ийн нэгдүгээр хавсралт “Даатгагч, даатгалын мэргэжлийн оролцогчид тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлт”-ын шинэчилсэн найруулгын төсөлд даатгагчийг технологид суурилсан шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ, бизнес загварыг хөгжүүлэх бодлого, журамтай байхыг мөн иргэд, даатгуулагчдын цахим технологийн мэдлэг боловсрол дутмаг байх эсхүл цахим технологид алдаа гарах зэрэг асуудлаас даатгуулагчид хохирч үлдэх эрсдэл өндөр байдаг тул цахимаар болон аливаа дэвшилтэт технологи ашиглан даатгалын гэрээ байгуулахад тавигдах шаардлагуудыг тус тус тусгаж өгсөн.

Мөн Хороо нь санхүүгийн үйлчилгээнд шинээр нэвтэрч буй технологид суурилсан шинэлэг бүтээгдэхүүн, үйлчилгээ, бизнес загварыг Монгол улсын санхүүгийн зах зээлд нэвтрэхэд нь дэмжих зорилгоор санхүүгийн зохицуулагч байгууллагын хяналт, зохицуулалт дор хязгаарлагдмал хүрээг хамарсан бодит орчинд, тодорхой цаг хугацаанд технологид суурилсан бүтээгдэхүүнийг турших боломжийг олгох, зах зээлд оролцогчдод тавигдах шаардлагыг тодорхойлох, холбогдох харилцааг зохицуулах Сэндбокс журмыг боловсруулж, олон нийтээс санал авахаар Хорооны цахим хуудсанд байршуулаад байна.

## СУДЛААЧИЙН ИНДЭР

### ЗЭЭЛДЭГЧ ӨӨРИЙН САНХҮҮГИЙН ХЭРЭГЦЭЭ, ЧАДАМЖИД НИЙЦСЭН ЗЭЭЛЭЭР САНХҮҮЖИЖ БАЙГАА ЭСЭХ

Санхүүгийн зохицуулах хорооны Зах зээлийн судалгаа, хөгжлийн газар  
Гүйцэтгэсэн: С.Будбаяр

#### ХУРААНГУЙ

Энэхүү судалгааны ажлаараа хэрэглээний зээлийн түвшинг тодорхойлж, олон нийтийг өөрт өгөөжтэй зээл авах, өрийн урхинд орсон нөхцөлд хэрхэн түүнээс гарах талаар зөвлөмж хүргүүлэхийг зорилгоо.

Судалгааны ажил нь банк, ББСБ, ХЗХ-ны хэрэглээний зээлийн түвшинг тодорхойлж, бусад төрлийн зээлтэй харьцуулахад өндөр байгааг онцлон иргэдийг өөрт өгөөжтэй зээл авдаг байх хандлага үүсгэх хоёр төрлийн тест, зөвлөмж боловсруулсан. Түүнчлэн “Олон нийтийн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөр”-т зээлдэгчийн зээл авах боловсролыг нэмэгдүүлэх, мөн санхүүгийн удирдлагад хандах сэтгэлзүйн боловсролыг олгох нь чухал байгааг онцлолоо.

Энэхүү судалгаанд зээлдэгч өөрийгөө өрийн урхинд орсон эсэхээ шалгах, хэрвээ орсон бол хэрхэн өрийн урхинаас ангижрах, зээлээс бусад ямар эх үүсвэрээр санхүүжих боломжтой, цаашлаад зээлдэгчийн төлөвийг зан чанар, сэтгэлзүй талаас нь тайлбарласан нь онцлог юм.

Хүмүүс санхүүгийн үйлчилгээ, бүтээгдэхүүний талаар мэдээлэлтэй болсон боловч одоогийн нөхцөл байдалдаа хэрхэн тохируулах, хэрхэн хандлагаа өөрчлөх талаар төдийлөн ойлголтгүй байна. Санхүүгээ удирдах нь хүмүүсийн сэтгэлзүй, зан чанараас хамааран харилцан адилгүй байгаа нь энэхүү чиглэлээр боловсрол олгох хэрэгтэйг илтгэж байна.










#### ОРШИЛ

Иргэдэд хамгийн түгээмэл тулгардаг, чухал санхүүгийн шийдвэрүүд нь ажил, тээврийн хэрэгсэл, орон сууц, даатгал, хөрөнгө оруулалтын талаарх шийдвэрүүд гэж тодотгосон байдаг. Эдгээр сонголтууд нь эдийн засаг, санхүүгийн бодит байдлаас хамааран өөрчлөгдөж байгаа учир аливаа мэдээлэлд няхуур хандах чадварыг бий болгох үндсэн ойлголт, чадавхад анхаарлаа

төвлөрүүлэх шаардлагыг үүсгэсэн. Энэхүү судалгаа нь нийт зээлдэгчид өөрийн хэрэгцээ болон чадамжид нийцсэн зээл, санхүүжилтийг авч чадаж байгаа эсэх талаар дурдана.

Хүмүүс ихэвчлэн тухайн үеийн сэтгэл хөөрөл болон орчин үеийн техник технологийг худалдан авах хүсэлдээ автан зээлээр худалдан авалт хийдэг байна. Ихэнх тохиолдолд хадгаламж байдаггүй учраас албан болон албан бус сектороос зээлдэг. Энэхүү судалгаагаар дамжуулан санхүүгийн боловсрол олгох, төлөвлөлт хэрхэн хийн, зээлийн урхи гэж юу болох, түүнээс хэрхэн ангижрах, зээл авахгүйн тулд ямар арга хэмжээ авах нь зүйтэй талаар мэдээлэл өгөхийг зорьсон.

Зураг 4. Зээлийн төрөл

 Цалингийн зээл	 Тэтгэврийн зээл	 Тэтгэврийн зээл
 Малчны зээл	 Орон сууцны зээл	 Хөрөнгө оруулалтын зээл
 Эргэлтийн хөрөнгийн зээл	 Төслийн зээл	 Зээлийн карт

#### • Хүмүүс яагаад зээл авдаг вэ?

Зээлийн төрөл, ангиллыг бид мэдэж авсан ба яагаад хүмүүс зээл авдаг талаар дэлгэрэнгүй тайлбарлая. Зээлдэгч болгон өөр өөр шалтгааны улмаас зээл авсан байдаг ба ихэнх тохиолдолд худалдан авалт хийх, туршлага хуримтлуулах, өмнөх зээлээ төлөх, тансаг хэрэглээнд зарцуулах, гэнэтийн хэрэгцээ шаардлагад ашиглах, мөрөөдөл,

#### НЭГ. ЗЭЭЛ, ТҮҮНИЙ ХЭРЭГЦЭЭ

Монгол улсын хувьд санхүүгийн байгууллагаас зээл авч буй хүмүүсийн хэмжээ, зээлийн дансны тоо болон зээлж буй давтамж нь дэлхийн дунджаас болон өндөр орлоготой улсуудаас өндөр түвшинд байна. Гэсэн хэдий ч тэдгээр зээлүүд нь зайлшгүй хэрэгцээнд тулгуурласан эсэх, эргэн төлөх чадамжаар баталгаажсан эсэх зэргийг нэгтгэн харвал үр дүн муутай байгаа юм.

#### • Зээл гэж юу вэ?

Санхүүгийн байгууллага, хувь хүнээс өөрийн хувийн хэрэгцээ болон бизнесийн үйл ажиллагаанд шаардлагатай санхүүжилтийг тодорхой хугацаатай, хүүтэй, эргэн төлөх нөхцөлтэй авахыг зээл гэж энгийнээр тодорхойлдог.

хүслээ биелүүлж бизнесээ эхлүүлэх зэрэг шалтгаанаар зээл авдаг байна.

#### • Зан чанар ба зээлийн төлөв

1992 онд Голдберг нь хамгийн анх “Том 5” буюу “Big 5” тестийг боловсруулсан бөгөөд энэхүү тестээр та өөрийнхөө 5 үндсэн хэмжигдэхүүн болох нээлттэй байдал, ухамсартай байдал, бусдыг ойлгодог байдал, экстраверсизм ба нейротизм зэргийн


хөгжлийн түвшинг мэдэж авна. Зан чанараас шалтгаалан зээл авах болон төлөх хандлага, зээл авч буй эх үүсвэр зэрэг нь харилцан адилгүй байдаг учир та зан чанараа шалгаад үзэхэд илүүдэхгүй билээ.

Хүснэгт 1. Зан чанар ба зээлийн төлөв

ЗАН ЧАНАР	ШИНЖ ЧАНАР	ЗЭЭЛИЙН БАЙДАЛ
Нээлттэй байдал	Зохион байгуулалттай хариуцлагатай сахилга баттай	Албан бус сектороос буюу эргэн тойрны хүмүүсээс зээл авах хандлага ихтэй байдаг.
Ухамсартай байдал	Нийтэч, идэвхтэй, ухамсартай	Ихэвчлэн албан сектороос буюу банк, ББСБ, ХЗХ-с зээл авдаг. Зээлийн нөхцөл, гэрээг сайтар уншиж танилцдаг.
Бусдыг ойлгодог байдал	Халамжтай, итгэл даахуйц, зөрчилдөөнөөс ангид	Бусдын үгэнд автаж зээл ихээр авдаг ч зээл авсны дараа харамсах тохиолдол олон байдаг.
Экстравер-сизм	Тайван, сэтгэл хөдлөл тогтвортой	Хамгийн их зээл авах хандлагатай байдаг хүмүүс
Нейротизм	Сониуч, бүтээлч, уран сэтгэмжтэй	Зээл авсны дараа маш их харамсдаг учир нейротизм зан чанартай хүмүүст зээлийг тохиромжгүй.

**ХОЁР. ХЭРЭГЛЭЭНИЙ ЗЭЭЛИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ**


Зураг 5. Хэрэглээний зээлийн нийт зээлд эзлэх хувь



Хэрэглээний зээл, иргэдийн өрийн дарамтыг цалингийн өсөлттэй уялдуулан аажмаар бууруулах зорилгоор тэтгэврийн зээлээс бусад хэрэглээний зээлийн хувьд өр, орлогын харьцааны дээд хязгаарыг 2019 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн 60 хувиар шинэчлэн тогтоох шийдвэрийн хэрэгжилтийн үр дүнд арилжааны банкуудын хэрэглээний зээлийн хэмжээ 2019 оны 2 дугаар улирлаас эхлэн буурсан үзүүлэлттэй байна. Улмаар ББСБ болон ХЗХ-ны хэрэглээний зээлийн хэмжээ нэмэгдсэн.

Санхүүгийн байгууллагуудын олгож буй зээлийг зориулалтаар нь ангилан харахад хэрэглээний зээлийн эзлэх хувь өндөр хэвээр байна. 2018 оны 4 дүгээр улирлын байдлаар арилжааны банкны иргэдэд олгосон хэрэглээний зээлийн нийт зээлд эзлэх хувь нь 32.5 хувь байсан бол 2020 оны 2 дугаар улирлын байдлаар 28.6 хувь болж буурсан үзүүлэлттэй байна. Харин ББСБ-ын 2019 оны 1 дүгээр улирлаас 2020 оны 2 дугаар улиралд олгосон хэрэглээний зээлийн хэмжээ нь тогтмол өсөлттэй байв. ХЗХ-ны иргэдэд олгосон хэрэглээний зээлийн хувь нь 2018 оны 1 дүгээр улирлаас 2020 оны 2 дугаар улирлын хугацаанд савлагатайгаар үзүүлэлттэй байв. Энэ нь 2019 оны 4 дүгээр сарын 01-ний өдрийн шинэчлэн тогтоосон шийдвэртэй шууд хамааралтай.

Зураг 6. Чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь



2018 оны 1 дүгээр улирлаас 2020 оны 2 дугаар улиралд арилжааны банкны чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь нь тогтмол нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

ББСБ-ийн чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хэмжээ тогтмол хувиар буурсан үзүүлэлттэй байгаа бол ХЗХ-ны чанаргүй зээлийн хувь нь савлагаатай байгаа хэдий ч 2018 оны 1 дүгээр улирлаас 2020 оны 2 дугаар улирлын хугацаанд 1.36 хувиар буурсан байна.

**Та аливаа бараа бүтээгдэхүүнийг худалдан авахаасаа өмнөх дараах 7 асуулыг өөрөөсөө асууж хэвшвэл, өөрийгөө хэрэгцээгүй худалдан авалт, өрийн урхинд орох, зээлээ эргэн төлөх чадваргүй болох гэх мэт асуудлуудаас хамгаалж чадна.**

Та доорх 7 асуултаудад 2 болон түүнээс дээш удаа “үгүй” гэсэн хариулт өгсөн бол тухайн бараа бүтээгдэхүүн, үйлчилгээг зээлээр худалдан авахаа түр хугацаанд хойшлуулсан нь дээр гэж зөвлөж байна. Тухайн үедээ сэтгэл хөөрөлд үл автан, санхүүгийн тооцоотой байснаар та өөрийгөө өрийн урхинд орохоос сэргийлж чадах юм.

1. Та тогтвортой ажил эрхэлдэг үү?
2. Та гэнэт ажлаасаа гарвал хэр хугацаанд зээлийн төлөлтөө хийсээр байж чадах вэ?
3. Танд урьдчилгаа төлбөр төлөх бололцоо байгаа юу?
4. Зээлийн бүхий л шаардлагыг биелүүлж, гэрээний хугацаа дуустал хариуцлагатайгаар эргэн төлөлтөө хийж чадах уу?
5. Танд мөнгөний гэнэтийн хэрэгцээ гарахад үүнийг зохицуулж чадах уу?

6. Та худалдан авах гэж буй бараа бүтээгдэхүүн, үйлчилгээндээ зориулан зээл авч, тогтмол хугацаанд төлбөр төлөх гэж байгаадаа итгэлтэй байна уу? Та өөрийнхөө сонголтыг үнэ цэнтэй гэж бодож байна уу?
7. Эцэст нь та өөрийнхөө шийдвэрийг зөв гэдэгт итгэлтэй байна уу?

### ГУРАВ. ӨРИЙН УРХИ ГЭЖ ЮУ ВЭ?

Өрийн урхи гэдэг нь нь өндөр төлбөр бүхий үндсэн зээл, хүүгийн төлбөрөө төлж барагдуулж чадахгүй болох нөхцөл байдалд орох юм. Аажим аажмаар өрийн урхинд орох нь төдийлөн анзаарагдахгүй байх аюултай байдаг ба нэг л мэдэхэд өрийн урхинд орсон байдаг. Ингэснээр та одоогийн зээлээ төлж чадахгүй дахин зээл авах, улмаар ирээдүйд төлбөрийн чадваргүй болж, орлого болгон тань зээлийн төлөлтөд зарцуулагдах нөхцөл байдалтай тулгарна.

**Таны авч буй зээл зайлшгүй хэрэгцээнд зориулагдсан уу? Зээлээ эргэн төлөхөд танд ямар нэгэн асуудал тулгардаг уу? Та доорх асуултуудыг өөрөөсөө асуун, өрийн урхинд орсон эсэхээ шалгаад үзээрэй.**

Та доорх асуултын 4 болон түүнээс дээш асуултад “тийм” гэсэн хариулт өгсөн бол та хувийн болон өрхийн санхүүдээ анхаарах цаг нь болсон гэдгийг илтгэнэ. Учир нь та өрийн урхинд орсон гэсэн үг юм. Харин 3 болон түүнээс цөөн удаа “тийм” гэж хариулсан бол та аюулгүй гэсэн утгыг илэрхийлнэ.

1. Байнгын хэрэгцээндээ зориулж зээл авдаг уу?
2. Зээлээ төлөхийн тулд дахин зээл авдаг уу?
3. Та кредит картаар байнгын хэрэгцээгээ хангадаг уу?
4. Кредит картын төлбөрөө хугацаа хэтрүүлж төлдөг үү?
5. Хэрэглээний төлбөрөө төлөх хугацаа хэтрүүлдэг үү?
6. Ирээдүйн орлогоо барьцаалж зээл авдаг уу?
7. Сар бүрийн тогтмол төлдөг зардлууд тань нэмэгдэж байна уу?
8. Утас, суурин болон зөөврийн компьютер зэрэг хэрэгслүүдийг авахдаа сар бүр тогтмол төлөхөөр тохиролцоо хийсэн үү?
9. Банк нь таны зээлийн хүсэлтээс татгалзаж байна уу?
10. Орлогын тань 50 хувиас илүү нь сар бүр төлдөг тогтмол зардалд зориулагддаг уу?
11. Орлогын тань 70 хувиас илүү нь сар бүрийн тогтмол зардалд зарцуулагддаг уу?

#### • Зээлээс бусад орлогын эх үүсвэр

Зээл авч, санхүүжилтийн эх үүсвэрээ бүрдүүлэх нь муу арга биш хэдий ч, хувь хүний болон өрхийн санхүүгээ нарийн төлөвлөөгүй бол, энэ нь танд асуудал үүсгэх магадлалтай билээ. Доорх орлого нэмэгдүүлэх боломжуудыг судлан, хэрэгжүүлж чадсанаар өөрийгөө болон эргэн тойрны хүмүүсээ өрийн урхинаас хамгаалаарай.

Зураг 7. Өрхийн орлого нэмэгдүүлэх боломж



#### • Өрийн урхинаас хэрхэн ангижрах вэ?

Зээл авах нь боловсрол, орон сууц, сургалтын төлбөр, түрээс, автомашин худалдан авах гэх мэт эсвэл өөрийн бизнесээ санхүүжүүлэхэд тохиромжтой хэдий ч буруу удирдсан өр нь таны ирээдүйн санхүүгийн байдалд муугаар нөлөөлнө. Үүнээс гадна таны сөргөөр нөлөөлөх магадлалтай байдаг ба энэ нь стресст хүргэж болзошгүй. Бага хэмжээний өр, зээлийг удирдах хялбар хэдий ч орон сууцны зээл, үл хөдлөх хөрөнгийн зээл гэх зэрэг нь урт хугацааны учир илүү их чадвар шаардагддаг билээ.

Зураг 8. Өрийн урхинаас ангижрах арга зам

1. Зээлийн эргэн төлөлтийн график байгуулах
2. Сарын орлого болон сар болгон тогтмол төлдөг зардлуудаа жагсаан бичих (Төсөвчин, Хувийн санхүүч, Миний санхүүч утасны платформуудадsss тэмдэглэх боломжтой)
3. Үргэлж цаг тухай бүрт нь төлбөрөө төлөх /Боломжтой бол цалингийн дансаа зээлийн данстайгаа холбож автоматжуулах/
4. Хамгийн өндөр дүнтэй өрөө хамгийн эхэнд төлж барагдуулах
5. Урьдчилан төлөх төлөвлөгөө зохиох
6. Нэмэлт зээл авахаас зайлсхийх
7. Танд олон зээл байгаа бол тэднийгээ нэгтгэх
8. Өөрийгөө аливаа өвчин болон бэртэж гэмтэхээс болгоомжлох
9. Эдийн засгийн хүнд нөхцөл байдал тулгарвал хувийн санхүүгээ хэрхэн хамгаалах талаар аргачлал зохиох
10. Орлогоо нэмэгдүүлэх ямар нэгэн арга хайж олох
11. Зээлийн эргэн төлөлтийн хугацаагаа сунгах гэж оролдохгүй байх
12. Зээлээ төлж барагдуулсны дараагаар банкнаас “үлдэгдэл төлбөргүй” гэсэн бичиг авах
13. Зээлийн оноогоо тухай бүрт нь шалгаж байх

• **Хувь хүний санхүүгийн төлөвлөлт**

Хувь хүний санхүүгийн төлөвлөлт гэдэг нь хувь хүн эдийн засгийн хувьд сэтгэл ханамжтай байхын тулд мөнгөө удирдаж буй үйл явц юм. Хэрэв та санхүүгийн төлөвлөлтөө зөв хийж чадвал дараах ач тустай билээ.

Зураг 9. Санхүүгийн төлөвлөлт гаргах үе шат



Санхүүгийн сахилга баттай өрх, хувь хүн нь улирал, хагас болон бүтэн жилээр төлөвлөгөөгөө гарган мөрддөг. Үүний тулд орлого, зарлагаа урьдчилж тооцоолсон байна. Өрхийнхөө төсвийг тогтмол хөтлөх явцдаа тодорхой хугацаанд хянаж, шинжилгээ хийгээд өнгөрсөн хугацаанд ямар зүйлд мөнгө их зарцуулсан, юунаас хэмнэлт гаргаж чадсанаа дүгнэж байх шаардлагатай. Энэ үйл явцад хамгийн чухал нь өрхийн гишүүн бүр тооцоотой байх хандлагын болоод үйлдлийн өөрчлөлт бий болгож байвал үр дүн харагдана.

• **Зардал бууруулах арга замууд**

Зээл авч, сар бүр тогтмол хүүгийн зардал гаргахгүйн тулд аливаа гэнэтийн үйл явдал тохиолдоход бусдаас зээлэхгүйгээр өөрийн нөөц бололцоогоор даван гарахын тулд та хуримтлал үүсгэх нь зүйтэй. Хэрэв та хуримтлалгүй бол дараах аргуудаас өөрт тохирох аргачлалыг сонгосноор санхүүгийн эрх чөлөөнд хүрэх боломжтой. “Төсөвчин” утасны аппликейшнээр дамжуулан та төсөв хуримтлал, зээл, мөргөжийн тооцоолуур ашиглах боломжтой. Мөн санхүүгийн төлөвлөлт, хадгаламж, зээл, даатгал, татвар, тэтгэвэр тэтгэмж, хөрөнгө оруулалтын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг “Санхүүгийн боловсрол”-ын цахим хаяг болох ([www.sankhuugiinbolovsrol.mn](http://www.sankhuugiinbolovsrol.mn))-аас аваарай.

1. Зардлуудаа тодорхойлох
2. Мөнгөө тогтмол хадгалах
3. Мөнгө хадгалж буй зорилгоо тодорхойлох
4. Дугуйт төсвийн аргыг хэрэгжүүлэх
5. Тухайн үеийн сэтгэл хөөрлөөр худалдан авалт хийхгүй байх
6. Хадгаламжийн дансаа автоматжуулж, тогтсон хугацаанд мөнгө татдаг болгох

7. Даатгуулах
8. Амьдралын зөв хэмнэлтэй болох
9. Өр тавихаас зайлсхийх
10. Гар утсаараа дамжуулан төсвөө хянадаг болох (Төсөвчин, Миний санхүүч)

**ДҮГНЭЛТ**

Санхүүгийн Зохицуулах хороо болон ЭН-АР-СИ-СИ ХХК хамтран хийсэн судалгааны ажил болох “Монгол улсын санхүүгийн хүртээмжийг үнэлэх түүвэр судалгаа”-наас харахад санхүүгийн байгууллагад хадгаламжтай иргэдийн тоо дэлхийн дунджаас 8 хувиар, өндөр орлоготой орнуудаас 36 хувиар бага байв. Хуримтлал хийх нь өөрийн хэрэгцээг хангахаас гадна гэнэтийн мөнгөний асуудал тохиолдоход зохицуулах бололцоогоор хангаж чадна. Хуримтлалтай иргэдийн тоо бага байгаа нь хэрэглээний зээлийн хэмжээ их байх гол шалтгаан болж байгаа юм. Хуримтлалтай байснаар зээлээс зайлсхийх, өрийн урхинд орохоос хамгаалж чадна.

Зээл нь тийм ч буруу орлогын эх үүсвэр биш ч, сайтар төлөвлөлт хийхгүйн улмаас эрсдэл учруулж болзошгүй. Төлөвлөлтгүй худалдан авалт нь их хэмжээний зээл, цаашлаад өрийн урхинд оруулах магадлалыг нэмэгдүүлэх учир хувь хүн өөрийн болон өрхийн төлөвлөгөөг зөв гаргаж, хянах нь хамгаас чухал юм.

Зээлдэгч нь өөрийн чадамжид нийцсэн зээлээр санхүүжиж байгаа эсэх нь чухал бөгөөд “Олон нийтийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх хөтөлбөр 2015–2021”-ийн хүрээнд өнгөрсөн жилүүдэд санхүүгийн боловсрол олгох чиглэлээр зөвлөгөө мэдээлэл хүрсэн. Хүмүүс нь санхүүгийн үйлчилгээ, бүтээгдэхүүний талаар мэдээлэлтэй болсон боловч одоогийн нөхцөл байдалдаа хэрхэн тохируулах, хэрхэн хандлагаа өөрчлөх талаар мэдэхгүй байна. Санхүүгээ удирдах нь хүмүүсийн сэтгэлзүй, зан чанараас хамааран харилцан адилгүй байгаа нь энэхүү чиглэлээр боловсрол олгох хэрэгтэйг илтгэж байна.

**САНАЛ**

1. Зээлээ төлж барагдуулсны дараа банк эсвэл зээлдүүлэгчээсээ “үлдэгдэл төлбөргүй” гэсэн бичиг авч баталгаажуулдаг болох. Энэ нь 2 талд аливаа асуудал үүсэхээс урьдчилан сэргийлэх боломжийг олгоно.
2. Иргэн бүрт “зээлийн оноо” үүсгэх ба энэ нь зээлдэгчийн зээлжих чадварыг илэрхийлнэ. Зээлдэгчийн зээлийн мэдээлэл, өмнөх зээлийн түүхийг нь нарийн судлан үзэх шаардлагагүйгээр шуурхай, хялбар зээлийг шийдэх боломжтой болно.
3. Зээлээр худалдан авалт хийхээс өмнө, өөрөөсөө асууж
4. Өрийн урхинд орсон эсэхээ шалгах тестийг илүү боловсронгуй болгож, зээлдэгчдийг тогтмол хугацаанд шалгадаг болох
5. “Олон нийтийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх хөтөлбөр”-т иргэдэд зөв зохистой зээл авах чиглэлээр боловсрол олгох зорилго, зорилт, арга хэмжээний төлөвлөгөөг тусгах. Түүнчлэн олон нийтийн санхүүгийн боловсролыг олгоход санхүүгээ удирдах сэтгэлзүйн боловсролыг хамтад нь авч үзэх

**ЭХ СУРВАЛЖ**

Монгол эх сурвалжууд:

- [1] Монголбанк. “Санхүүгийн боловсрол: Зээл”
- [2] Монголбанк. “Санхүүгийн боловсрол: Өрхийн төсөв”
- [3] Санхүүгийн боловсрол цахим хаяг <https://www.sankhuuginbolovsrol.mn/>

Гадаад эх сурвалжууд:

- [4] Adhil Shetty. “13 smart ways for borrowers to get out of a debt trap.” (2019)
- [5] Narendra Nathan. “11 signs that show you are falling into a debt trap.” (2019).
- [6] Kapoor, Jack R., Les R. Dlabay, and Robert James Hughes. Personal finance. Boston, MA: McGraw–Hill Irwin, 2009.
- [7] Olga Goldfayn & Nathanael Vellekoop. “Personality traits and household’s borrowing behavior.” (2018).
- [8] Riju Mehta. “Home loan.” (2020).
- [9] Shivam Abrol . “Why do People borrow money.” (2019).

**ТАНИЛЦУУЛГА****ХҮРТЭЭМЖТЭЙ ДААТГАЛЫН АСУУДЛААРХ АЗИЙН ОРНУУДЫН МЭДЛЭГ, ТУРШЛАГА СОЛИЛЦОХ СҮЛЖЭЭ**

/MEFIN: Mutual Exchange Forum on Inclusive Insurance/

Филиппин, Тайланд, Вьетнам/–ы даатгалын зохицуулагч байгууллагууд гишүүнчлэлд нь багтдаг байв. Гишүүн болох эрхийг Азийн орнуудад нээлттэй болгосноор уг сүлжээнд 2015 онд Пакистан, 2017 онд Шри-Ланк улс гишүүнээр элсэн орсон.

2016 онд үйл ажиллагааныхаа бүтцийг тодорхойлж, Бүс Нутгийн Удирдах Хороо /Regional Steering Committee/, түүний бүрэлдэхүүнд Бодлого, зохицуулалтын, Бизнес загварын, Мэдлэг удирдлагын, Чадавх бэхжүүлэлтийн чиглэлээр үйл ажиллагаа явуулах үндсэн 4 ажлын хэсгийг, 2017 онд Гамшгийн эрсдэлийн даатгалын ажлын хэсгийг нэмэлтээр байгуулсан.

**АЛСЫН ХАРАА:**

Дэлхийн хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн даатгалын зохицуулалт, хяналтын стандартыг авч хэрэгжүүлэх замаар ядуурлыг бууруулах, эдийн засаг нийгмийн хөгжлийг дэмжихэд туслах.

**ЭРХЭМ ЗОРИЛГО:**

Улс орон бүрийн хууль эрх зүйн зохицуулалтын онцлогийг харгалзан үзэж, зохих бодлогыг боловсруулахад зайлшгүй шаардлагатай мэдлэг, туршлага солилцох механизм байх.

**ТОВЧ ТАНИЛЦУУЛГА:**

Хүртээмжтэй даатгалын асуудлаарх Азийн орнуудын мэдлэг, туршлага солилцох сүлжээ нь 2013 онд үүсгэн байгуулагдсан ба Себугийн тунхаглалд хамтран ажиллахаар зөвшилцсөн Азийн 6 орон /Индонези, Балба, Монгол,

**БҮТЭЦ:**

- Бүс нутгийн удирдах хороо нь хүртээмжтэй даатгалын асуудлаарх Азийн орнуудын мэдлэг, туршлага солилцох сүлжээний гишүүн орон тус бүрээс сонгогдсон үндсэн болон орлох үүрэг бүхий төлөөлөгчөөс бүрдэх ба ажлын хэсгүүдэд санал, зөвлөгөө өгч ажилладаг. Жил бүр хоёр удаа хуралдах бөгөөд өмнөх оны ажлын хэсгийн үйл ажиллагааны гүйцэтгэлийг үнэлж, дараа жилийн ажлын төлөвлөгөөг батлах үүрэгтэй.
- Хэрэг эрхлэх газрын чиг үүргийг Азийн Бичил Даатгалын Зах Зээлийн Зохицуулалтын Тогтолцоог Дэмжих Хөтөлбөр /RFPI/ хэрэгжүүлдэг байна.
- Ажлын хэсгүүд нь дараах зорилготой:

**Бодлого, зохицуулалтын ажлын хэсэг** /TWG on Regulation and supervision/: Даатгалын үндсэн зарчим (ICP)–д тулгуурлан Хүртээмжтэй даатгалд тавигдах шаардлага, бизнесийн загвар, хэрэглэгчийн боловсролыг дээшлүүлэх, хамгаалах, болон хяналт шалгалтын практиктэй холбогдох материалыг бий болгох. Ингэхдээ байгалийн гамшиг, хөдөө аж ахуйн салбар, жижиг дунд үйлдвэрлэл болон эрүүл мэндийн салбарт илүүтэй анхаарах;

**Бизнес загварын ажлын хэсэг /TWG on Business model/:** Хүртээмжтэй даатгалын бүтээгдэхүүн хөгжүүлэлт, үнэ бүрдүүлэлт, бүтээгдэхүүний багц, актуарын тооцоолол, боломжит борлуулалтын суваг болон нөхөн төлбөрийн удирдлагатай холбоотой практик тохиолдлуудыг нэгтгэсэн материалыг бий болгох;

**Мэдлэг удирдлагын ажлын хэсэг /TWG on Knowledge management/:** Хөтөлбөрт оролцогч гишүүдийн хооронд мэдээлэл солилцох платформ болон арга хэрэгслүүдийг судалж, хэрэглэх, ашиглах зааварчилгаа гаргах;

**Чадавх бэхжүүлэлтийн ажлын хэсэг /TWG on Capacity building/:** Зохицуулалтын байгууллага дотроо Хүртээмжтэй даатгалын хэлтэс, алба, техникийн хороо, ажлын хэсгийг удирдах арга барилыг тодорхойлох зааварчилгааны материалыг бий болгох;

**Гамшгийн эрсдэлийн даатгалын ажлын хэсэг /TWG on Disaster risk insurance/:** MEFIN-ий сүлжээн дэх улсууд хоорондоо Гамшгийн эрсдэлийн даатгалын бодлого, эрх зүйн орчин дахь өөрчлөлтийн талаарх мэдээллийг солилцох, эдгээр өөрчлөлтийн даатгалын зах зээлд үзүүлэх нөлөөллийг үнэлэх, үүндээ тулгуурлан гамшгийн эрсдэлийн даатгалын шинэ санаа, санаачлага, загварыг санал болгох.

Тус сүлжээ нь Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг /GIZ/, Хүртээмжтэй Даатгалын нэвтрэлт /Access to Inclusive Insurance/, Германы эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн яам /BMZ/ болон Азийн Хөгжлийн банк /ADB/-тай хамтран ажилладаг.

#### Хэрэгжүүлсэн гол үйл ажиллагаа:

MEFIN нь 2013–2015 онд RFPI Asia I – Бичил даатгал, 2016–2018 онд RFPI Asia II – Хүртээмжтэй даатгал хөтөлбөрийн хүрээнд дараах үйл ажиллагааг тус тус хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Хүртээмжтэй даатгалын хууль эрх зүйн зохицуулалтыг бий болгох хүрээнд Индонез улс – бичил даатгалын гранд загвар, бичил даатгалын бүтээгдэхүүн ба маркетингийн сувгийн зохицуулалт, Монгол улс – хүртээмжтэй даатгалын тодорхойлолт, бүтээгдэхүүнд тавигдах шаардлага, Балба улс – бичил даатгалын захирамж, Пакистан улс – хүртээмжтэй даатгал болон байгууллагын даатгалын төлөөлөгч болон технологид суурилсан борлуулалтын сувгийн зохицуулалт, Филиппин улс – бичил даатгалын үндэсний стратеги, Вьетнам улс – бичил даатгалын гарын авлагыг гаргаж ажилласан;
- Хүртээмжтэй даатгалд инновацийг бий болгох чиглэлээр Филиппин 6, Шри-Ланк 1, Непал 4, Пакистан 3, Индонез 4, Вьетнам 2, Монгол 2 нийт 22 бизнесийн загварын танилцуулга гаргасан;
- Хөтөлбөрт оролцогчдын чадавхыг сайжруулах чиглэлээр хүртээмжтэй даатгалын талаарх олон улсын хурал, уулзалт, сургалтуудад холбогдох ажилтнуудыг хамруулахад дэмжлэг үзүүлэхээс гадна Санхүүгийн боловсролд зориулсан зөвлөмж бичиг, Гамшгийн эрсдэлийн талаарх гарын авлага, Зохицуулах үйл ажиллагааны нөлөөг үнэлэх гарын авлагыг боловсруулан гаргаж, хэвлүүлсэн.

2019–2022 онд тус Сүлжээ нь RFPI Asia III хөтөлбөрийн хүрээнд Зүүн өмнөд Азийн улс орнууд дахь нэн ядуу, ядуу болон эмзэг байдалтай жижиг, дунд бизнес эрхлэгчдийг уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөгөөр бий болдог гамшигт үзэгдлийн эрсдэлээс даатгалын тусламжтайгаар хамгаалах зорилго дэвшүүлэн ажиллаж байна.



## ӨРГӨН ДУРАН

### “УУР АМЬСГАЛЫН БОЛОН ЦАР ТАХЛЫН ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ НЬ” СЭДЭВТ ОЛОН УЛСЫН ЗӨВЛӨЛДӨХ ЦАХИМ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ ЗОХИОН БАЙГУУЛАГДЛАА



ХБНГУ–ын Олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг (GIZ), Хүртээмжтэй даатгалын асуудлаарх Азийн орнуудын мэдлэг туршлага солилцох сүлжээ (MEFIN)–тэй хамтран 2020 оны 9 дүгээр сарын 29, 30–ны өдрүүдэд “Уур амьсгалын болон цар тахлын гамшгийн эрсдэлийг бууруулах нь” сэдвийн хүрээнд Төр–Хувийн хэвшлийн Олон улсын зөвлөлдөх ээлжит 9 дүгээр уулзалт, хэлэлцүүлгийг цахимаар зохион байгууллаа. Цахим хэлэлцүүлэгт MEFIN–ий гишүүн болон бусад холбогдох байгууллагын нийт 70 орчим даатгалын салбарын мэргэжилтэн, зохицуулагч байгууллагын төлөөлөл, зочин илтгэгчид оролцсон ба тус хэлэлцүүлгээр дараах 4 чиглэлийн хүрээнд санал бодол, туршлага, мэдлэгээ солилцлоо. Үүнд:

- Даатгал, хамгаалах систем албан бус секторт дутагдаж буй суурь болох нь;
- Албан бус секторын олон талт байдал ба даатгалд хамрагдах арга зам;
- Эрэлтэд суурилсан гамшгийн эрсдэлийг санхүүжүүлэх шийдлүүд, тэдгээрийн хэрэгцээ;
- Эмзэг байдлыг бууруулах, гамшгийг удирдахад даатгалын салбарын гүйцэтгэх үүрэг.

Хэлэлцүүлгийн хүрээнд яригдсан онцлох асуудлуудыг товчлон хүргэвэл:

- Цар тахлын улмаас үүссэн хохирол албан бус секторт хамгийн их ажиглагдаж байна. Марокко, Этиоп зэрэг улсуудад хэрэгжиж буй гамшгийн даатгалын хөтөлбөрүүдийн үр дүнгээс харахад албан бус секторын эрсдэлд өртөмтгий байдал, үүссэн хохирлыг бууруулах гол арга зам нь даатгал болон нийгмийн хамгаалал байна. /Meghan Schmidt, Английн Хөгжлийн Судалгааны Хүрээлэнгийн Судлаач/
- Албан бус сектор дахь эрсдэлийг бууруулахад зорилтот этгээдүүдийг онцлог шинжээр нь ангилан авч, тэдгээрт тусгайлан зориулсан даатгалын бүтээгдэхүүнийг хөгжүүлэх шаардлагатай. Судалгааны дүнгээс албан бус секторт ажиллаж буй эмэгтэйчүүдийн оролцоо санхүүгийн салбарт, нэн ялангуяа даатгалын салбарт хангалтгүй байна. /Jaime Aristotle, CARD MRI хөтөлбөрийн үүсгэн байгуулагч/
- Эрсдэлийг бууруулах бүтээгдэхүүнийг боловсруулахдаа зорилтот бүлгийн эрэлт хэрэгцээг судалж, технологийн дэвшилтэт шийдлүүдтэй уялдуулсан байх шаардлагатай. /Junjau Perez, Филиппин улсын даатгалын холбооны тэргүүн/

- Гамшгийн эрсдэлийг үр дүнтэйгээр бууруулах бүтээгдэхүүнийг боловсруулж, зах зээлд нэвтрүүлэхэд төр–хувийн хэвшлийн хамтын ажиллагаа чухал ач холбогдолтой. /Pascale Lamb, A2ii хөтөлбөрийн зөвлөх шинжээч/

Манай улсын хувьд гамшгаас хамгаалах үйл ажиллагааг шуурхай, үр дүнтэй зохион байгуулахад даатгалын салбарын оролцоо нэн чухал шаардлагатай байгаа бөгөөд бусад улс орнуудын сайн туршлагад үндэслэн гамшгийн эрсдэлийн даатгалтай холбогдох зохицуулалтыг сайжруулан, олон нийтийг хямд үнэтэй, хялбар ойлгомжтой даатгалд хамруулах замаар гамшгийн эрсдэлийг бууруулах боломжтой юм.

### АЗИЙН ДААТГАЛЫН ЗОХИЦУУЛАГЧ БАЙГУУЛЛАГУУДАД ЗОРИУЛСАН ХҮРТЭЭМЖТЭЙ ДААТГАЛЫН СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАГДАВ

/Inclusive insurance training program for insurance supervisors in Asia/



Олон улсын даатгалын хянан шалгагчдын холбоо (IAIS)–оос 2020 оны 9 дүгээр сарын 1–10–ны өдрүүдэд “Inclusive insurance training program for insurance supervisors in Asia” сэдвийн хүрээнд цахим сургалт зохион байгууллаа.

Сургалтын хүрээнд газар тариалан түлхүү давамгайлсан Филиппин болон Энэтхэг улсуудын хувьд хүртээмжтэй даатгалын бүтээгдэхүүн илүү эрчимтэй хөгжсөн байгааг онцолсон бөгөөд улс орон бүр Хүртээмжтэй даатгалыг хөгжүүлэхэд тохиолдож буй хүндрэл бэрхшээлүүдийн талаар харилцан мэдээлэл солилцсон юм. Тухайлбал, нэг талаас зохицуулагч байгууллагын зүгээс бага дунд орлоготой иргэдийг хямд өртгөөр даатгалд хамруулах, нөгөө талаас даатгагч–бизнес эрхлэгч ашигтай ажиллах гэсэн ашиг сонирхлын зөрүүтэй байдал, даатгалын хураамжийн түвшин бага, даатгалын борлуулалтын суваг, дэд бүтцийн хөгжил сул, даатгалын бүтээгдэхүүний эрэлт тодорхойгүй, зорилтот хэрэглэгчид нь бичиг үсэг тайлагдаагүй, мэдлэг сул гэх мэт асуудлууд гардаг байна. Иймд сургалтад оролцогчид эдгээр хүндрэл бэрхшээлийг даван туулахын тулд зохицуулагч байгууллага, даатгагч болон даатгуулагчдын хамтын ажиллагааг сайжруулах, асуудлыг шийдвэрлэх арга замуудыг тусгасан үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулахаар ажиллаж байна.

Манай улсын хувьд хүртээмжтэй даатгалын зохицуулалтыг 2014 онд нэвтрүүлснээс хойш одоогийн байдлаар хүртээмжтэй даатгалын 14 бүтээгдэхүүн зах зээлд борлуулагдаж байгаа бөгөөд Гамшгийн эрсдэлийн хүртээмжтэй даатгалыг хөгжүүлэх, олон нийтийн даатгалын талаарх мэдлэг, мэдээллийг нэмэгдүүлэх талаар түлхүү анхаарч ажиллахаар төлөвлөөд байна.

**ЦАХИМ ГАРЫН ҮСЭГ, ДИЖИТАЛ ПЛАТФОРМ СЭДЭВТ ТУРШЛАГА СОЛИЛЦОХ УУЛЗАЛТЫН ТУХАЙ**

**/ A2ii-IAIS supervisory peer exchange meeting: E-signatures and digital onboarding/**



Олон улсын даатгалын хянан шалгагчдын холбоо (IAIS)-оос 2020 оны 9 дүгээр сарын 03-ны өдөр “Supervisory peer exchange on e-signatures and digital onboarding” сэдэвт цахим хэлэлцүүлэг зохион байгуулсан.

Шинэ төрлийн коронавирус /Ковид-19/ цар тахлын энэ үед дижитал даатгалын үйлчилгээг эрчимжүүлэхэд цахим гарын үсэг чухал ач холбогдолтой. Хэдий тийм ч даатгалын салбарт цахим үйлчилгээний хэрэглээ бага, энэ талаарх иргэд, даатгуулагчдын мэдлэг хангалттай бус байна.

Уг хэлэлцүүлгээр Бразил, Өмнөд Африк, Энэтхэг, Сингапур зэрэг улсын даатгалын салбарын хянан шалгагч нар өөрийн улсын даатгалын салбарын цахим гарын үсэг, дижитал платформтой холбоотой дараах зохицуулалт, практик туршлагын талаар мэдээлэл солилцсон. Үүнд:

- Энэтхэг улс нь Ковид-19 цар тахалтай холбоотойгоор 2020 оны сүүл хүртэл хадгаламжийн бус урт хугацааны даатгалыг цахим гарын үсгээр баталгаажуулахыг зөвшөөрч туршилтын шатандаа явж байна. Энэ ажлын хүрээнд “Aadhaar” дижитал системийг даатгалын гэрээ хийх, банкны данс нээхэд харилцагчийг таних зорилгоор ашиглаж байна.
- Бразил улс нь цахим гарын үсгийн хэрэглээ даатгалын зах зээлд эрчимжиж буйтай холбогдуулан бичил даатгалыг цахимаар борлуулах журам, цахим гарын үсгийн талаар гарын авлагыг шинэчлэн боловсруулсан.
- Хонгконг улс нь Шинэ төрлийн коронавирус /Ковид-19/ цар тахлын үеийн нөхцөл байдалтай холбоотойгоор 2020 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийг дуустал даатгалын гэрээ байгуулах, нөхөн төлбөр нэхэмжлэх үйл явцыг түргэн шуурхай болгох, хэрэглэгчидтэй биечлэн уулзах тохиолдлыг багасгахын тулд уг үйл ажиллагааг цахимаар баталгаажуулах түр арга хэмжээ авч эхлээд байна. Энэ түр арга хэмжээнд даатгалын гэрээ болон нөхөн төлбөрийг цахим гарын үсгээр, газар дээр нь бичлэг хийх, пин кодоор баталгаажуулах, нэг удаагийн нууц үг ашиглах, гарын үсэг зураад и-мейлээр явуулах зэргээр баталгаажуулах боломжтой болгож өгсөн байна. Урт хугацааны даатгалын бүтээгдэхүүний хувьд онлайнар видео уулзалт хийх зохицуулалтын орчинг бий болгохоор сандбокс орчин дээр туршилт хийж ажиллаж байна.

Хэлэлцүүлгийн үеэр цахимаар гэрээ байгуулах үед тулгарч буй хууль, эрх зүйн саад бэрхшээл, даатгуулагчийн мэдээллийн аюулгүй байдал, цахим гарын үсгийн төрлүүдийн талаар ярилцлаа.

Оролцогч улсуудын туршлагаас дүгнэхэд хэрэглэгчийг таних шалгууруудыг бууруулан, тоон гарын үсэг, нэг удаагийн код зэрэг арга хэрэгслүүдийг ашиглаж эхэлсэн байна.



## САНХҮҮГИЙН БОЛОВСРОЛ

### ДААТГАЛЫН АЧ ХОЛБОГДОЛ

Хүн бүр амь нас, эрүүл мэнд, өмч хөрөнгөө хамгаалахын тулд учирч болох эрсдэлээс сэргийлдэг хэдий ч “Гай газар дороос” гэдэг шиг аливаа өвчин зовлон, аюул осол хэлж ирдэггүй хийсэж ирдэг. Энэ үед хүн сэтгэл санааны, бие махбодийн, эд хөрөнгийн хохирол амсаж, түүнийг барагдуулах, даван туулахад тодорхой хэмжээний санхүүгийн дарамт үүсдэг.



Иймээс аливаа хувь хүн, албан байгууллагын хэвийн байдлыг алдагдуулах, санамсаргүй, эрсдэл дагуулсан үйл явцаас үүсэх хохирлыг бууруулах, нөхөх санхүүгийн үр дүнтэй арга хэрэгсэл бол даатгал юм.

Хүмүүс хэсэг бүлгээрээ дундын сан бүрдүүлж, тэрхүү сангаасаа хохирол учирсан нэгэндээ туслах нь даатгалын үндсэн хэлбэр юм. Тэрхүү санг үүсгэхэд хамтарч оролцох хүмүүсийн тоо олон байх тусам нэг хүнд ногдох зардлын хэмжээ буурдаг бөгөөд учирсан хохирлыг барагдуулахад хүрэлцэхүйц байх боломжтой. Үүнтэй адил даатгал бол бага зардал гарган их хэмжээний хохирлоос хамгаалагдах боломж буюу хариуцлага, хамгаалалт, амар тайван байдлыг эрэлхийлсэн эрсдэлийн удирдлагын энгийн шийдэл гэж ойлгож болно.

Гэнэтийн эрсдэл хэнд ч, хэзээ ч тохиолдох магадлалтай тул түүнээс хэрхэн урьдчилан сэргийлэх, шилжүүлэх, хүлээн зөвшөөрөх зэрэг арга хэмжээг авч болох бөгөөд учирч болзошгүй хохирлыг бусдад шилжүүлэх буюу даатгалд хамрагдах боломж байдаг. Эрсдэлийг даатгагдах болон даатгагдахгүй эрсдэл гэж ангилдаг. Гэнэтийн шинж чанартай, хохирол нь мөнгөөр илэрхийлэгдэх боломжтой эрсдэлийг даатгагдах эрсдэл гэдэг.

#### Даатгуулж болох эрсдэлийн төрлүүд

- Хувь хүний эрсдэл – Амь нас, эрүүл мэнд учирч болзошгүй эрсдэлүүд. Жишээ нь: *автомашинь осолд өртөх, өвчин тусах г.м.*
- Эд хөрөнгийн эрсдэл – Таны эд хөрөнгөд бүрэн буюу хэсэгчлэн хохирол учруулж болзошгүй эрсдэлүүд. Жишээ нь: *хулгайд юмаа алдах, орон гэр нь гал түймэрт өртөх г.м.*
- Хариуцлагын эрсдэл – Аливаа хариуцлагагүй болон санаандгүй үйлдлээс болж бусдын эд хөрөнгө, эрүүл мэндэд хохирол учруулж болзошгүй эрсдэлүүд. Жишээ нь: *автомашин жолоодож байхдаа бусдыг гэмтээх, эд хөрөнгөд нь хохирол учруулах г.м.*

#### Даатгалд хамрагддаггүй эрсдэлийн төрлүүд:

- Элэгдэл, хорогдол
- Техникийг шалган турших явцад гарсан хохирол
- Хувь сэтгэл санааны хохирол, байгууллагын нэр хүндийн эрсдэл

Даатгал нь даатгалын гэрээний үндсэн дээр иргэд, байгууллагууд эрсдэлээ даатгуулж даатгалын хураамж төлөх, гэрээний хүчинтэй хугацаанд даатгалын тохиолдол болсон үед даатгалын компаниас нөхөн төлбөр олгох итгэлцэл дээр суурилдаг үйл ажиллагаа юм. Иймд иргэн та даатгагч, даатгуулагчийн хооронд үүсэх гэрээний харилцаа болон даатгалтай холбогдох дараах үндсэн ухагдахууныг ойлгох нь зүйтэй.

#### Даатгалтай холбоотой үндсэн ухагдахуунууд:

№	Нэр томьёо	Тодорхойлолт
1	Даатгал	Ирээдүйд учирч болох аливаа эрсдэлийг шилжүүлэх, багасгахад чиглэсэн үйл ажиллагаа
2	Даатгалын зүйл	Даатгалд хамрагдаж байгаа эд хөрөнгө, иргэдийн амь нас, эрүүл мэнд, хуульд харшлаагүй эдийн бус ашиг сонирхол
3	Даатгалын гэрээ	Даатгагч, даатгуулагчийн хооронд үүсэх даатгалын харилцааг зохицуулсан эрх зүйн баримт бичиг
4	Даатгалын үнэлгээ	Даатгалын объектыг үнэлж, мөнгөн дүнгээр илэрхийлсэн хэмжээ
5	Даатгалын тохиолдол	Даатгуулсан зүйлд учирсан хохирол, гэрээнд заасан болзол бүрдэхийг
6	Даатгалын хураамж	Даатгуулагч даатгалын зүйлээ даатгуулсны төлөө даатгагчид төлөх төлбөр бөгөөд даатгалын үнэлгээнээс хамаарч хураамжийг тооцдог
7	Даатгалын нөхөн төлбөр	Гэрээний дагуу даатгалын тохиолдол үүссэн нөхцөлд даатгагчаас даатгуулагчид олгох мөнгөн хөрөнгө
8	Даатгалын баталгаа	Даатгалын компаниас даатгасныг баталгаажуулан даатгуулагчдаа өгч буй баримт бичиг бөгөөд даатгалын гэрээний салшгүй хэсэг
9	Даатгалын хугацаа	Даатгалын гэрээнд заасан хүчинтэй хугацаа



Техникийн эрсдэл



Ахуйн эрсдэл



Байгалийн эрсдэл



Араатан амьтны нөлөөгөөр үүсэх эрсдэл



Бусдад хорлогдох эрсдэл



Зам тээврийн осолд өртөх эрсдэл



Архаг хууч өвчин



Ердийн өвчин



Гэнэтийн өвчин

**Даатгалын бүтээгдэхүүн, үйлчилгээ**

Даатгалын тухай хуульд зааснаар даатгалыг урт хугацааны ба ердийн даатгал гэж ангилж бөгөөд ангилал нь сайн дурын болон албан журмын гэсэн төрөлтэй байна. Даатгалын төрөл тус бүр нь хэлбэртэй байх бөгөөд албан журмын даатгалын хэлбэрийг хуулиар тогтоодог бол сайн дурын даатгалын хэлбэрийг Санхүүгийн зохицуулах хороо тогтооно.

Хувь хүн, хуулийн этгээд сайн дурын үндсэн дээр даатгуулах эсэх нь сонголттой бол сайн дурын даатгал, харин аливаа үйл ажиллагаанд оролцож байгаа этгээд заавал даатгуулахаар хуульчилсныг албан журмын даатгал гэнэ.

**Даатгалын ангилал**

	Даатгалын ангилал, төрөл	Тодорхойлолт	Жишээ
Ангилал нь	Ердийн даатгал	Аливаа гэнэтийн ослын улмаас хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, эдийн бус ашиг сонирхолд учрах эрсдэлээс хамгаалах, богино хугацаатай, амьдралын бус даатгал	Гэнэтийн осол, эмчилгээний зардлын, эд хөрөнгийн, авто тээврийн хэрэгслийн, ачааны, барилга угсралтын, газар тариалангийн, мал амьтдын даатгал г.м
	Урт хугацааны даатгал	Хүний амь нас, эрүүл мэндэд учрах эрсдэлээс хамгаалах, амьдралын баталгаатай холбоотой санхүүгийн хүндрэлийг шийдвэрлэх, урт хугацаатай, амьдралын даатгал	Хугацаат амьдралын, насан туршийн, хуримтлалын, тэтгэврийн, эрүүл мэндийн г.м
Төрлөөр нь	Албан журмын	Хуульд заасны дагуу заавал даатгуулах даатгал	Жолоочийн хариуцлагын албан журмын даатгал
	Сайн дурын	Иргэн, хуулийн этгээдүүд өөрийн хүсэлтийн үндсэн дээр даатгуулж болох даатгал	Хуульд заавал даатгуулах гэж зааснаас бусад даатгал

Жишээлбэл, Иргэн А автомашин жолоодож замын хөдөлгөөнд оролцох үедээ санамсаргүй бусдын автомашиныг мөргөж гэмтээх тохиолдолд гуравдагч этгээдэд учруулсан хохирлоо жолоочийн хариуцлагын даатгалаар нөхөн төлүүлж болно. Харин тээврийн хэрэгслийн даатгалд даатгуулсан бол өөрийн автомашинд учирсан хохирлыг барагдуулж болох юм. Үүнээс машин барьж авто замын хөдөлгөөнд оролцдог л бол жолооч та жолоочийн хариуцлагын даатгалд заавал даатгуулах учиртай, харин тээврийн хэрэгслээ даатгуулах эсэх нь таны сонголт юм.


*/Хуулиар болон СЗХ-ноос тогтоосон нийт даатгалын хэлбэрээс дараах хэлбэрүүдийг сонгож тайлбарласан болно/*

№	Даатгалын төрөл	Агуулга
	Гэнэтийн осол, эмчилгээний зардлын даатгал	Аливаа гэнэтийн осол, гэмтлийн улмаас хүний амь нас, эрүүл мэндэд хохирол учрахад даатгагчаас даатгуулагч эсхүл даатгалын гэрээнд заасан эрх бүхий этгээдэд мөнгөн төлбөр төлөх нөхцөл бүхий даатгал. Үүнд хөдөлмөрийн чадвар алдахтай холбоотой эмнэлэг, эмчилгээ, мэс заслын зэрэг зардлын даатгал хамаарна

№	Даатгалын төрөл	Агуулга
1	Авто тээврийн хэрэгслийн даатгал	Авто тээврийн хэрэгслийг эзэмших, ашиглах үед тухайн тээврийн хэрэгсэлд хохирол учрахад даатгагчаас даатгалын гэрээнд заасан эрх бүхий этгээдэд мөнгөн төлбөр төлөх нөхцөл бүхий даатгал. Тээж яваа ачаа болон аливаа хариуцлагын даатгал хамаарахгүй
2	Хариуцлагын даатгал	Аливаа этгээдийн санамсар болгоомжгүй буруутай үйлдлийн улмаас бусдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд хохирол учрахад даатгагч даатгалын гэрээнд заасны дагуу эрх бүхий этгээдэд мөнгөн төлбөр төлөх нөхцөл бүхий даатгал
3	Санхүүгийн даатгал	Санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой хохирол учрахад даатгагч даатгалын гэрээнд заасан эрх бүхий этгээдэд мөнгөн төлбөр төлөх нөхцөл бүхий даатгал. Бизнес тасалдлын даатгал үүнд хамаарна
4	Жолоочийн хариуцлагын даатгал	Жолооч замын хөдөлгөөнд оролцох үедээ бусдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд хохирол учруулахад даатгагчаас хохирогчид мөнгөн төлбөр төлөх, хохирогчийн эрхийг хамгаалах нөхцөл бүхий даатгал
5	Эрүүл мэндийн даатгал	Эрүүл мэндийн холбогдолтой зардлыг даатгалын гэрээгээр даатгуулагчид төлөх нөхцөл бүхий даатгал. Үүнд хөдөлмөрийн чадвар алдалтын даатгал хамаарна
6	Тэтгэврийн даатгал	Даатгалын гэрээгээр тохиролцсон хугацаанд даатгуулагчид тэтгэвэр буюу мөнгөн төлбөр төлөх нөхцөл бүхий даатгал
7	Хуримтлалын даатгал	Даатгуулагч гэрээт хугацааны эцэст амьд байх болон тухайн хугацаанаас өмнө нас барах гэсэн нөхцөлүүдээр даатгуулагч, эсвэл гэрээнд заасан эрх бүхий этгээдэд даатгагч баталгаатай мөнгөн төлбөр төлөх хугацаат болон хөрөнгө оруулалтын хавсарсан даатгал. Гэрлэлтийн, сургалтын зардлын, орон сууцны хуримтлалын даатгал үүнд хамаарна

Даатгалын хэлбэр нь даатгалын бүтээгдэхүүнээс бүрдэх бөгөөд даатгалын бүтээгдэхүүн нь даатгагчаас хэрэглэгчдэд санал болгож, худалдан борлуулж байгаа даатгалын үйлчилгээг ойлгоно. Жишээлбэл, хүүхдийн гэнэтийн ослын даатгал, хашаа, байшингийн даатгал, гадаадад зорчигчийн даатгал, хүүхдийн боловсролын хуримтлалын даатгал г.м.

Даатгалын компаниудын санал болгодог олон төрлийн даатгалын бүтээгдэхүүнээс хэрхэн сонголт хийх талаарх зөвлөгөөг дараах зургаас харж болно.




## ХЭРЭГЛЭГЧ

### ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ, ҮЙЛЧЛҮҮЛЭГЧДИЙН ЭРХ АШГИЙГ ХАМГААЛАХ

#### ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН СУДАЛГАА

Санхүүгийн зохицуулах хорооны Хяналт шалгалт, зохицуулалтын газар нь хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг хянаж, барагдуулахаар санал дүгнэлт гаргаж, хуульд заасан эрх хэмжээний хүрээнд урьдчилан шийдвэрлэх чиг үүргийг

хэрэгжүүлдэг. 2020 оны 3 дугаар улирлын байдлаар Хяналт шалгалт, зохицуулалтын газарт хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдээс нийт 130 өргөдөл, гомдол ирсэн байна.



Тайлант хугацаанд үнэт цаасны зах зээл, хадгаламж зээлийн хоршооны үйл ажиллагаатай холбоотой өргөдөл, гомдлын тоо буурсан бол даатгалын салбар болон ББСБ-ын үйл ажиллагаатай холбоотой өргөдлийн тоо өссөн байна.

#### ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТ

Тайлант хугацаанд нийт 130 өргөдөл, гомдол ирснээс дараах байдлаар өргөдөл, гомдлыг шийдвэрлэсэн байна:

Өргөдөл, гомдлын шийдвэрлэлт	Өргөдлийн тоо
Шийдвэрлэж, хариуг өгөв. Үүнээс:	
Хугацаанд нь шийдвэрлэсэн	108
Хугацаа хэтэрч шийдвэрлэсэн	-
Шийдвэрлэх шатандаа байгаа. Үүнээс:	
Хуулийн хугацаанд хянагдаж буй	22
Хугацааг нь сунган хянагдаж буй	-

Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн үйл ажиллагааны процесс, авах арга хэмжээний хүрээ харилцан адилгүй байгаагаас хамааран тухайн өргөдлийн шийдвэрлэх хугацаа өөр өөр байгаа хэдий ч нийт өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацаа 22 хоног болж өмнөх оны мөн үетэй харьцуулахад 5 хоногоор уртассан нь дийлэнх өргөдөл, гомдлын утга, агуулгууд нь тухайн мэргэжлийн нарийвчилсан ур чадвар шаардсан, оролцогч талуудын хоорондын илүү төвөгтэй маргааны хэлбэртэй болсноос гадна зарим зөрчлийн шинжтэй өргөдлийн дагуу зөрчлийн хэрэг бүртгэлт хийх, прокурорын байгууллагаар хянуулах болсонтой холбоотой.

Өргөдөл, гомдол шийдвэрлэх дундаж хугацаа (хоногоор):



## КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

### ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ /ТУЗ/-ИЙН ДЭРГЭДЭХ ХОРООДОД ГҮЙЦЭТГЭХ ҮҮРЭГ



ТУЗ–д үүргээ гүйцэтгэхэд нь туслалцаа үзүүлэх үүрэгтэй тусгай хороодыг байгуулах нь чухал бөгөөд үүнд аудит, мөн компанийн хэмжээ ба эрсдэлийн төлвөөс хамааран эрсдэлийн удирдлагын, стратегийн ба цалин урамшууллын хороод багтана. Хувьцаат компанийн ТУЗ нь аудитын, цалин, урамшууллын, нэр дэвшүүлэх хороодтой байх бөгөөд эдгээр хороодын гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь ТУЗ–ийн хараат бус гишүүдээс бүрдэнэ.

#### Аудитын хороо

Аудитын хорооны дарга нь ТУЗ–ийн хараат бус гишүүн байх ёстой бөгөөд тус хороо нь дараах үүрэгтэй:

- компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийг олон улсын стандартад нийцүүлэх, дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаа, санхүүгийн тайлан, санхүү, эдийн засгийн бусад мэдээллийн үнэн бодит байдалд хяналт тавих;
- дотоод аудитын нэгжийн удирдлага, ажилтныг томилох, цалин, урамшууллыг тогтоох санал боловсруулах;
- хөндлөнгийн аудитын байгууллагыг сонгох, түүний ажлын хөлсний хэмжээг тогтоох талаар санал боловсруулах;
- их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэлд хяналт тавих, дүгнэлт гаргах;
- компанийн дүрэмд заасан болон ТУЗ–өөс шаардлагатай гэж үзсэн бусад асуудал.

#### Цалин урамшууллын хороо

- ТУЗ–ийн гишүүн, гүйцэтгэх удирдлага болон бусад эрх бүхий албан тушаалтны цалин, урамшууллын талаар баримтлах бодлогыг батлах, түүний хэрэгжилтэд хяналт тавих;

- ТУЗ болон гүйцэтгэх удирдлага, бусад эрх бүхий албан тушаалтанд олгох цалин, урамшууллын дээд хязгаарыг тогтоох, тогтоосон хэмжээнд багтаан цалин, урамшуулал олгох санал боловсруулах;
- компанид мөрдөж байгаа ажлын үр дүнтэй холбогдсон компанийн урамшууллын системийн зорилгыг тодорхойлж, үр дүнг үнэлэх.

#### Нэр дэвшүүлэх хороо

- компанийн ТУЗ–ийн гишүүн болон гүйцэтгэх удирдлагад нэр дэвшигчид тавих шаардлагыг тодорхойлж, ур чадвар, мэдлэг, боловсрол, ажлын туршлага зэргийг үнэлэх шалгуурыг тогтоох;
- ТУЗ–ийн гишүүн болон гүйцэтгэх удирдлагад нэр дэвшигчийн ур чадвар, мэдлэг, боловсрол, ажлын туршлага, харин хараат бус гишүүний хувьд энэ хуулийн 79.1–д заасан шаардлагыг хангаж байгаа эсэхэд үнэлэлт, дүгнэлт өгөх;
- ТУЗ–ийн гишүүнд нэр дэвшигчийг бүртгэн сонгон шалгаруулалт хийж, хувьцаа эзэмшигчдийн хуралд шууд нэр дэвшүүлэх;
- ТУЗ болон гүйцэтгэх удирдлагын гишүүдийн үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгөх;
- гүйцэтгэх удирдлагатай байгуулах гэрээний нөхцөлийг боловсруулах;
- ТУЗ–ийн гишүүнээс бусад компанийн эрх бүхий албан тушаалтны ажлын гүйцэтгэлд гүйцэтгэх удирдлагаас өгсөн үнэлгээнд дүгнэлт гаргах;
- Компанийн тухай хуулийн 59.5–д заасан үндэслэлээр ТУЗ–ийн бүрэн эрх нь дуусгавар болсноос хойш гурван жилийн хугацаанд тухайн ТУЗ–ийн гишүүн байсан этгээдийг нэр дэвшүүлэхээс татгалзах.

# ОЛОН УЛСЫН ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

## ШИНЭ ТӨРЛИЙН КОРОНА ВИРУСТ ХАЛДВАР (КОВИД-19)-ЫН ЦАР ТАХЛЫН УЛМААС ДААТГАЛЫН САЛБАРТ АВЧ ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ АРГА ХЭМЖЭЭ

2020 оны 1 дүгээр сард Хятадын Ухань мужид шинэ төрлийн корона вирус халдвар /Ковид-19/-ын анхны тохиолдол бүртгэгдэж, Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас 2020 оны 3 дугаар сарын 11-ний өдөр Ковид-19 вирус халдвар цар тахлын хэмжээнд болсон тухай зарласан. Энэ үйл явдлаас хойш 10 сарын хугацаанд дэлхий нийтээр нийгэм, эдийн засгийн асар их хохирлыг амсаад байна.

Үүнээс улбаалан олон улсад даатгалын компаниуд зах зээлийн үнэлгээнийхээ 48 орчим хувийг алдсан бөгөөд ялангуяа амь нас, эрүүл мэндийн даатгалын компаниудын хувьд дунджаар 58%-аар буурч хүнд цохилтод оржээ. Ковид-19 вирус шинжилгээ, эмчилгээний өртөг нь эрүүл мэндийн даатгалын үнэлгээг өсгөж, улмаар 2021 онд даатгалын шимтгэлийн зардлууд нэмэгдэх магадлалтай байна. Эдгээр зардлыг нөхөх, төлбөрийн чадвараа хадгалж үлдэхийн тулд 2021 онд даатгалын хураамж 4-40%-аар нэмэгдэх хандлагатай байгаа юм.

### Гадаад улс орнууд Ковид-19 цар тахлын улмаас даатгалын салбарт үүсэж болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлж авсан арга хэмжээ

Эдийн засаг хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (OECD)-аас гаргасан судалгаанаас харахад Ковид-19 цар тахалтай холбоотойгоор олон улсын даатгалын зохицуулагч байгууллага, хянан шалгагч, даатгалын холбоод болон даатгалын компаниуд дараах гурван үндсэн чиглэлээр хариу арга хэмжээ авсан байна. Үүнд:

#### 1. Үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангах:

Зохицуулагч байгууллагаас даатгалын үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангах хүрээнд даатгалын компаниудын бизнесийн үйл ажиллагааг хэвийн явуулах төлөвлөгөөг гарган, дижитал цахим даатгалын үйлчилгээг хэрэглэгчиддээ үзүүлэх чиглэл өгөх зэрэг арга хэмжээг авч ажиллаж байна. Түүнчлэн зарим улс орны зохицуулагч байгууллагууд бизнесийн тасралтгүй байдлыг хангах төлөвлөгөөг хэрхэн дагаж мөрдөж байгаад хяналт тавьж, зохицуулалтын байгууллагуудаас тайлан, төлөвлөгөө зэрэг зүйлсүүдийг тэдгээрт хүндрэл бэрхшээлгүйгээр авах арга хэмжээг зохион байгуулж байгаа бөгөөд даатгалын компанийн ноогдол ашгийн төлбөр болон бусад хойшлуулах боломжтой зардлыг хойшлуулж, хүнд нөхцөл байдалд орсон даатгалын компаниудад төв банк болон бусад банкаас зээл тусламж авах үйл ажиллагааг дэмжин ажиллаж байна.

#### 2. Төлбөрийн чадвар, хөрвөх чадварын эрсдэлийг бууруулах:

Төлбөрийн чадвар хөрвөх чадварын эрсдэлийг бууруулах чиглэлийн хүрээнд даатгалын хянан шалгагч нар нь одоо байгаа санхүүгийн болон хяналт шалгалтын мэдээлэлд үндэслэн зах зээлийн, андеррайтерийн болон хөрвөх чадварын эрсдэлийг стресс тест дээр үндэслэн тогтмол хяналт тавин ажиллаж байна. Уг цар тахалтай холбоотойгоор даатгалын компаниуд бага зэргийн эрсдэл үүсэхэд хянан, шалгагч нар илүү нарийвчилсан мэдээллийг даатгагчаас шаардаж эрсдэлийг тогтмол үнэлж ажиллаж байгаа болно. Зарим улс орны хянан шалгагч нар хяналт, шалгалтын журамд өөрчлөлт

оруулах замаар хөрөнгө оруулалтын хязгаарлалт, тайлагналыг уян хатан болгох зохицуулалтуудыг хийж байна.

#### 3. Даатгуулагчдын эрх ашгийг хамгаалах:

- Ковид-19 цар тахалтай холбоотойгоор тухайн даатгуулагчид хохирол үүссэн бол хэрхэн даатгагчаас нөхөн төлбөр нэхэмжлэх талаарх зөвлөгөөг даатгуулагчид хүргэж ажиллаж байна.
- Даатгагчид даатгуулагчдад санхүүгийн дэмжлэг үзүүлэх үүднээс хураамжийн төлбөрийг хойшлуулах, буцаан олголт олгох нөхцөлийг уян хатан болгох зэрэг арга хэмжээ авч ажиллаж байна. Зарим улс орнуудад засгийн газар болон зохицуулагч байгууллагаас дээрх арга хэмжээг авч ажиллахыг шаардаад байна.
- Даатгалын компаниуд нөхөн төлбөр олгох, нөхөн төлбөрийн материалыг бүрдүүлэх журамд хөл хорионы дэглэмтэй уялдуулан өөрчлөлт оруулж байна. Мөн зарим улсын засгийн газар болон зохицуулагч байгууллагууд нь эдгээр өөрчлөлтийг даатгагч нараас шаардаж байгаа юм. /Жишээлбэл, даатгуулагчид цар тахлын хөл хорионы үед бүрдүүлэхэд хүндрэлтэй зарим баримт бичгийг даатгуулагчаас шаардахгүй байх/
- Зарим даатгалын компаниуд даатгуулагч болон тодорхой төрлийн ажилчдад (эрүүл мэндийн ажилчид, жижиг, дунд бизнес эрхлэгчид гэх мэт) нэмэлт эрсдэл, нөхөн төлбөр олгох нөхцөлийг сайн дураараа санал болгож байна. /Жишээлбэл, БНСУ-д Ковид-19 вирусийн халдвараас үүдэн нас барах эрсдэлийг гэнэтийн ослын болон өвчний улмаас үүсэх эрсдэлд аль алинд нь хамааруулан үзэж байна. Итали, Сингапур зэрэг улсуудад хөл хорионд байгаа болон хэвтэн эмчлүүлж байгаа даатгуулагчид болон түүний гэр бүлд нь нэмэлт нөхөн төлбөр олгохоор болсон/

**Ковид-19 цар тахлын Монгол Улсын даатгалын салбарт үзүүлсэн нөлөөлөл болон Санхүүгийн зохицуулах хороо, даатгалын компаниудаас тус салбарт үүсэж болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор авсан арга хэмжээ**

#### Салбарын нөхцөл байдал:

Цар тахлын улмаас Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт хэсэгчлэн шилжсэн үеэс эхлэн 2020 оны эхний 3 улирлыг дуусгах хугацаанд даатгалын салбарт гарсан өөрчлөлтийг товч дүгнэн үзвэл дараах байдалтай байна. Үүнд:

- Санхүү, итгэлцэл, зээл, хариуцлагын даатгал зэрэг даатгуулагчийн бизнесийн үйл ажиллагааны тогтвортой байдал алдагдсантай холбогдох даатгалын бүтээгдэхүүнүүд болон гадаадад зорчигчийн гэнэтийн ослын даатгалын нөхөн төлбөрийн хэмжээ даатгагчдын тооцоолсноос давсан.
- Жолоочийн хариуцлага, тээврийн хэрэгслийн даатгалын тохиолдлын тоо өмнөх оны мөн үетэй харьцуулахад 9.8 хувиар буурсан боловч гадаад валютын ханшийн өсөлт автомашины

сэлбэг хэрэгслийн үнэд нөлөөлснөөр нөхөн төлбөрийн хэмжээ 2.3 хувиар өссөн.

- Ачааны даатгал, гадаад зорчигчийн гэнэтийн ослын даатгал зэрэг хил дамнасан үйл ажиллагаанд холбогдох даатгалын бүтээгдэхүүнүүдийн хураамжийн орлого буурах хандлагатай байсан боловч 3 дугаар улирлаас ачааны даатгалын борлуулалт өсч, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 36.7 хувиар нэмэгдэж, тус даатгалын үйл ажиллагаа хэвийн явагдаж эхэлсэн байв.

Шинэ төрлийн корона вирус (Ковид–19)–ын халдвар дотоодод илэрч, Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн энэ үед даатгалын компаниуд цахим горимоор үйл ажиллагаагаа хэвийн явуулж байна. Тухайлбал, даатгалын бүх компани утсаар болон фейсбүүк мессенжер буюу чатбот, 5 даатгалын компани эдгээрээс гадна цахим болон гар утасны аппликейшн ашиглан зөвлөгөө өгөх, даатгалын тохиолдлын талаар мэдээлэл болон нөхөн төлбөрийн баримт материалыг хүлээн авах зэргээр даатгалын үйлчилгээг үзүүлж байна.

2020 оны 11 дүгээр сарын 11–ний өдрөөс 26–ны өдрийн хооронд ердийн даатгалын компаниудын хувьд нийтдээ 2,025 даатгалын тохиолдол бүртгэгдэж, 819 тохиолдлын 338.4 сая төгрөгийн нөхөн төлбөрийг олгож, 1,312 даатгалын тохиолдол шийдвэрлэгдэх шатандаа хянагдаж байв.

#### **Цар тахлын улмаас авч хэрэгжүүлсэн арга хэмжээ:**

Ковид–19 цар тахал, улсын хэмжээнд хөл хорио тогтоосонтой холбогдуулан энэ оны 2 дугаар сард Хорооноос нөхцөл байдлыг судалж, гадаадад зорчигчийн гэнэтийн осол, эрүүл мэндийн даатгал, нийтийн зорчигч тээврийн даатгал, гадаад, дотоод ачаа тээврийн даатгалын бүтээгдэхүүний борлуулалт зогсох, иргэд, аж ахуй нэгжийн санхүүгийн чадамж буурснаар даатгалын хураамж төлөлт тасалдах, даатгалын нөхөн төлбөрийн зардал нэмэгдэх, компаниуд ажилтнуудаа халдвараас хамгаалж зайнаас ажиллуулах, ажлын цагийг багасгах зэргээс хамаарч даатгалын хураамжийн орлого буурах, үйл ажиллагааны тогтвортой байдал алдагдах гэх мэт олон сөрөг нөхцөл байдлууд үүсэж болзошгүй гэж таамаглаж байлаа.

Иймд дээрх таамаглалыг харгалзан үзэж Хороо нь 2020 оны 2 дугаар сарын 29–ний өдрөөс Үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангах, Төлбөрийн чадвар, хөрвөх чадварын эрсдэлийг бууруулах, Даатгуулагчдын эрх ашгийг хамгаалах гэсэн үндсэн 3 чиглэлээр дараах 8 арга хэмжээг авч хэрэгжүүлсэн . Үүнд:

1. Даатгалын гэрээ байгуулах, даатгуулагчдад нөхөн төлбөр олгох зэрэг хүнтэй тулж ажиллах үйл ажиллагаанд технологийн дэвшлийг ашиглах;
2. Иргэдэд даатгалын салбарын ач холбогдлыг таниулах, сурталчлах ажиллагааг эрчимжүүлэх;
3. Ипотекийн зээлдэгчийн урт хугацааны даатгалд хамрагдахыг дэмжих, эрчимжүүлэх;
4. Даатгалын мэргэжлийн оролцогчийн эрх олгох сургалт, шалгалтыг онлайн хэлбэрт шилжүүлэх талаар Холбоодтой хамтрах;
5. Даатгалын компаниудын төлбөрийн чадварын үзүүлэлтүүдэд нарийвчилсан хяналт тавьж, даатгалын үйл ажиллагаа хэвийн тогтвортой үргэлжлүүлэхийг бодлогоор дэмжих;

6. Даатгалын бүртгэлтэй холбогдох хүсэлтийг онлайнгаар авч шийдвэрлэх, цахим зөвшөөрөл бүртгэлийн үйл ажиллагааг эрчимжүүлэх;
7. Даатгалын нөхөн төлбөрийг түргэн шуурхай олгох нөхцөлийг бүрдүүлэх талаар даатгалын компаниудыг уриалах;
8. Ковид–19 вирус болон томуу, томуу төст өвчний эрсдлээс хамгаалах даатгалын шинэ бүтээгдэхүүн зах зээлд гаргах талаар санаачлага гарган ажиллах.

Дээрх арга хэмжээнүүдийн хүрээнд Хороо нь даатгалын компанийн санхүүгийн тайлагнал, төлбөрийн чадварын үзүүлэлтүүдэд стресс тест, эрт анхааруулах шинжилгээг ашиглан тогтмол хяналт тавьж, олон нийтийн даатгалын мэдлэг ойлголтыг дээшлүүлэх 2 теле, 1 аудио хичээлийг бэлтгэн, хөл хорионы улмаас хүндрэлтэй байдалд орсон иргэдэд зориулж гадаадад зорчигчийн гэнэтийн ослын даатгалын талаарх мэдээллийг түгээж, Хорооны бүртгэл зөвшөөрлийн үйл ажиллагааг цахимжуулах, хялбарчлах болон цахим даатгал, даатгуулагчдын эрх ашгийг хамгаалах зохицуулалт, компанийн засаглалыг сайжруулах зорилгоор Даатгалын багц дүрмийн нэмэлт өөрчлөлтийн төслийг боловсруулах зэрэг ажлыг хийж гүйцэтгэсэн ба цар тахалтай холбогдох 3 даатгалын бүтээгдэхүүнийг хянаж, бүртгэсэн болно. Цаашид дээрх 3 үндсэн чиглэлийн хүрээнд арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх ба цар тахлын үеийн эдийн засгийн хүндрэлийг бууруулах зорилгоор даатгалын салбараас хөрөнгийн зах зээлд хөрөнгө оруулах боломжийг нэмэгдүүлэхээр ажиллаж байна.

#### **Ковид–19 цар тахалтай холбогдох даатгалын шинэ бүтээгдэхүүнүүд:**

“Нэйшнл лайф даатгал” ХХК–аас нийгмийн хариуцлагынхаа хүрээнд цар тахлын халдварын эрсдэлт нөхцөлд ажиллаж буй эмнэлгийн эмч, ажилтнууд, онцгой байдлын албан хаагчид болон төрийн тусгай албан хаагчдын амь нас, эрүүл мэндийг үнэ төлбөргүй даатган, тодорхой хугацаанд буюу 2020 оны 9 дүгээр сар хүртэл хэрэгжсэн “Ковид–19 амь нас, хөдөлмөрийн чадвар алдалтын даатгал”–ын бүтээгдэхүүнийг энэ оны 4 дүгээр сарын 8–ны өдөр Санхүүгийн зохицуулах хороонд бүртгүүлж, 1,587 төрийн тусгай албан хаагчийг уг даатгалд хамруулан ажилласан.

Мөн тус компаниас Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдалд шилжсэн энэ үед нийт иргэд, даатгуулагчдад зориулсан шинэ төрлийн коронавирусын улмаас учирч болзошгүй санхүүгийн эрсдэлээс хамгаалагдах боломжтой “Ковид–19” эрүүл мэндийн даатгалын бүтээгдэхүүнийг боловсруулж ирүүлснийг Хороо цахимаар хянаж, 11 дүгээр сарын 24–ний өдөр бүртгэлээ. Ингэснээр иргэд, даатгуулагчид уг даатгалын бүтээгдэхүүнийг цахимаар худалдан авах, нөхөн төлбөрөө шуурхай шийдвэрлүүлж, тус вирусын халдвараар өвчилсний улмаас учирч болзошгүй санхүүгийн эрсдэлээс хамгаалагдах боломж бүрдсэн.


“Мандал Даатгал” ХК нь 2020 оны 5 дугаар сард Ковид хүртээмжтэй даатгалын бүтээгдэхүүнийг Хороонд бүртгүүлэн өөрийн харилцагч 82,000 даатгуулагчдаа энэ оны 9 дүгээр сарыг дуустал хугацаанд үнэ төлбөргүй даатгалд хамруулж ажилласан ба бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан уг бүтээгдэхүүнийг шинэчлэн, фейсбүүк чатботоор дамжуулан борлуулж, энэ оны 11 дүгээр сарын 27–ны өдрийн байдлаар 1,529 гэрээ байгуулаад байна.

# САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН САРЫН ТОЙМ

2020  
□ 10


## Хөрөнгийн зах зээл

33Ү /их наяд төгрөг/




Дунджаар 2.59 их наяд төгрөгт хүрсэн.

ТОП-20 индекс




17,458.1 буюу өмнөх сарын дунджаас 287.9 индексээр өссөн.

MSE A индекс



8,126.6 буюу өмнөх сарын дунджаас 122.1 индексээр буурсан.

MSE Б индекс



7,431.7 буюу өмнөх сарын дунджаас 25.7 индексээр нэмэгдсэн.



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж, www.mse.mn

Бүртгэлтэй үнэт цаасны тоо ширхэг

**15,138,005,043**

Хоёрдогч хувьцааны арилжааны үнийн дүн

/тэрбум төгрөг/



Нийт хийгдсэн хэлцлийн тоо

## БАРАА, ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛ

Биелсэн хэлцэл

**96**

Богцын нийт хэмжээ

**15,922**

Богцын нийт үнийн дүн

**5.1**

/тэрбум төгрөг/

Нэгж богцын дундаж үнэ

**517,9**

Эх сурвалж: Хөдөө аж ахуйн бирж, www.mse.mn

## Americas

S&amp;P 500 /^GSPC/

**3,269.96**

Vol 845,497,980

Dow Jones indus.AVG

**26,501.6**

Vol 142,836,358

Nasdaq composite index

**10,911.59**

Vol 874,510,482

NYSE composite index

**12,429.28**

Vol 1,193,366,900

## Asia Pacific

Topix index /tokyo/

**1,579.33**

Vol 1,310,329,900

Nikkei 225 /^N225/

**22,977.13**

Vol 766,608,300

Hang seng index

**24,107.42**

Vol 2,537,744,198

S&amp;P/ASX 200 index

**5,927.58**

Vol 871,366,470

## Europe, Middle East &amp; Africa

Euro stoxxs 50 Pr

**2,958.21**

Vol 467,907,483

FTSE 100 index

**5,577.27**

Vol 809,675,703

DAX index

**11,556.48**

Vol 85,600,358

CAC 40 index

**4,594.24**

Vol 109,096,908

ОЛОН  
УЛСЫНХӨРӨНГИЙН  
ЗАХ ЗЭЭЛ2020 оны 10 дугаар сарын 30-ны  
өдрийн байдлаарЭх сурвалж: [www.bloomberg.com](http://www.bloomberg.com)

2020  
□ 10



Эх сурвалж: Албан журмын даатгагчдын холбоо



Зах зээлийн судалгаа, хөгжлийн газар

## ОЛОН УЛСЫН ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ИНДЕКС

Таваарын ханш

2020 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр

Crude oil /WTI–New York/ Copper /LME/  
Gold Spot /ounce/ Coal /Tianjin

S&P 500 /^GSPC/  
**3,621.63**

Nikkei 225 /^N225/  
**26,433.62**




Эх сурвалж: www.finance.yahoo.com




Эх сурвалж: www.finance.yahoo.com

FTSE 100 /^FTSE/  
**6,266.20**

Nasdaq 100 Dec 20 (NQ=F)  
**12,277.00**



Эх сурвалж: www.finance.yahoo.com



Эх сурвалж: www.Bloomberg.com

Засгийн газрын IV байр, Бага тойруу-3 Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, Монгол Улс 15160

+976-51-264444

press@frc.mn

www.frc.mn

Санхүүгийн зохицуулах хороо

@FRC\_of\_Mongolia